



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ
УУРХАЙН ЯАМ



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул урхайн компаниудын засаглалын үнэлгээ

(2014 оны 5 дугаар сарын байдлаар)

Улаанбаатар хот
2014 он

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын Засаглалын үнэлгээ

Судлаач: **Д. БАЙЛЫХҮҮ**
Хянан тохиолдуулсан: **Л. БОЛОРМАА**

© Нээлттэй Нийгэм Форум, 2014

Энэхүү судалгааг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48

DDC
622
Б-188

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-99973-0-428-5

Хавтасны зургийг: Ц.Батбаатар /Фото сэтгүүлч/

ӨМНӨХ ҮГ

Уул уурхайн яам, Нээлттэй Нийгэм Форумгаас эрхлэн Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээний судалгаа хийн үр дүнг нь нэгтгэн уншигч Танд хүргэж байна.

Энэхүү судалгааг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн боловсруулсан арга зүй ашиглан Д. Байлхүү ахлагчтай судалгааны баг хийж гүйцэтгэсэн юм. Судалгаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн есөн компани хамрагдав.

Судалгааны дүнгээс үзэхэд манай улсад компанийн засаглалын зохицуулалт сайжирч, зарим ахиц дэвшил гарч байгаа ч судалгаанд хамрагдсан компаниудын засаглалын дундаж үнэлгээ хангалтгүй дүнтэй гарлаа. Ихэнх компани авбал зохих онооны гуравны нэгийг л авсан бөгөөд зөвхөн Оюу Толгой ХХК талыг нь буюу 48 хувийн үнэлгээ авчээ. Вьетнам, Филиппин, Тайланд, Хонгконг зэрэг Азийн орнуудын төрийн өмчит компаниудтай харьцуулахад манай улсын төрийн өмчит компаниудын засаглал даруй 1.5-2.5 дахин бага үнэлгээтэй байна. Ялангуяа, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, чухал хэлцэл, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хамгийн доголдолтой үзүүлэлтийн тоонд орж байна.

Аливаа компанийн засаглал тэр тусмаа нийтийн өмчид суурилж бизнес эрхэлж буй төрийн өмчит компанийн засаглал сайн байх нь компанийн ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлж, нийтийн баялгийг үрэн таран хийхээс сэргийлэхийн зэрэгцээ дотоод, гадаадын зээл, хөрөнгө оруулалт татаж урт хугацаанд тогтвортой ажиллах, улмаар үйл ажиллагаагаа өргөтгөх боломжийг эрс нэмэгдүүлдэг сайн талтай билээ. Уул уурхайн яам, Нээлттэй Нийгэм Форум энэхүү судалгааг хийлгэхдээ манай улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж буй төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын түвшин, түүнийг сайжруулах ажлын чиглэлийг тодорхойлохыг зорьсон юм. Энэ хүрээнд төр болон түүний хувьцааг эзэмшигч компанийн хоорондын харилцаа, төрийн төлөөлөл, түүнийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан зөвлөмжийг компани болгонд хүргүүлж байгаа болно.

Төгсгөлд нь, уг судалгааг амжилттай хийж гүйцэтгэн, нэгдсэн болон компани тус бүрийн тайланг боловсруулан гаргасан судалгааны багийнханд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

Товчилсон үг	5
Хүснэгт, зураг, графикийн жагсаалт	6
1. Оршил	7
Компанийн засаглалыг үнэлэх зорилго, хамрах хүрээ	7
Үнэлгээний арга зүй	8
2. Компанийн засаглалыг үнэлэх нь	11
Компанийн засаглал, түүний үндсэн элементүүд	11
Төрийн өмчит компани ба түүний засгалалын онцлог	13
3. Уул уурхайн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын үнэлгээний нэгдсэн дүн	15
Төрийн өмчит уул уурхайн компанийн засаглал ба түүний гол элементүүдэд өгсөн үнэлгээ	18
1. Хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалт	19
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал	20
3. ТУЗ, түүний ажиллагаа	21
4. Гүйцэтгэх удирдлага	24
5. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	25
6. Зарим чухал хэлцлийг хийж буй байдал	25
7. Ногдол ашиг	26
8. Компанийн дүрэм болон бусад эрхийн актууд, тэдгээрийн агуулга	27
9. Компани дахь хяналтын тогтолцоо	28
4. Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын түвшин-Дүгнэлт	29
5. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах-Зөвлөмж	31
6. Компаниудын үнэлгээний дүн	35
Эрдэнэт үйлдвэр ХХК	36
Монатом ХХК	39
Эрдэнэс Оюутолгой ХХК	42
Монголросцветмет ХХК	45
Эрдэнэс Монгол ХХК	48
Оюутолгой ХХК	51
Эрдэнэс ТТ ХК	54
Шивээ-Овоо ХК	57
Багануур ХК	60
7. Хавсралтууд	63
Хавсралт 1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын өнөөгийн түвшинг үнэлэх аргачлал	63
Хавсралт 2. Компанийн засаглалын үнэлэх үзүүлэлтүүдийн нийтлэг асуулгууд	65
Хавсралт 3. Компанийн засаглалын үзүүлэлтүүдийн түвшинг тодорхойлох асуулгын тоо	68
Лавлах материал	69

ТОВЧИЛСОН ҮГ

ГЗ	Гүйцэтгэх захирал
ГУ	Гүйцэтгэх удирдлага
КЗ	Компанийн засаглал
КТХ	Компанийн тухай хууль
МБББ	Мэдээллийн бодлогын баримт бичиг
НДХ	Нэр дэвшүүлэх хороо
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
ОУХА	Олон Улсын Хөгжлийн Агентлаг
СЗХ	Сонирхлын зөрчилтэй хэлцэл
ТК	Тооллогын комисс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НБД	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
ХЭ	Хувьцаа эзэмшигч
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭЭХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
ХШК	Хянан шалгах комисс
ЦУХ	Цалин, урамшууллын хороо
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан компаниудийн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн байдал
- Хүснэгт 2. Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын нэгдсэн үнэлгээ
- Хүснэгт 3. Азийн зарим орны компанийн засаглалын үнэлгээний дүн
- Хүснэгт 4. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалалтын үнэлгээ
- Хүснэгт 5. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хувьцаа эзэмшигчийн хурлын ажиллагаанд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 6. Төрийн өмчит уул уурхайн компаниудын ТУЗ-ийн ажиллагаанд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 7. Төрийн өмчит уул уурхайн компаниудын гүйцэтгэх удирдлагын ажиллагаанд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 8. Төрийн өмчит уул уурхайн компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 9. Төрийн өмчит уул уурхайн компаниудад зарим чухал хэлцлийг хийж буй байдалд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 10. Төрийн өмчит уул уурхайн компаниудын ногдол ашиг өгч буй байдалд өгсөн үнэлгээ
- Хүснэгт 11. Төрийн өмчит уул уурхайн компаниудын дүрэм ба бусад эрхийн акт, тэдгээрийн агуулгад өгсөн үнэлгээ
- Хүснэгт 12. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хяналтын тогтолцоонд өгсөн үнэлгээ
- Зураг 1. Компаниудын засаглалын үнэлгээ /хувиар/
- Зураг 2. Компанийн болон үнэлгээний үзүүлэлтүүдээр авсан үнэлгээний дундаж ба дээд, доод хэмжээ

Компани нь аль ч улс орны эдийн засагт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг аж ахуй эрхлэх хамгийн чухал хэлбэр юм. Тухайлбал, АНУ-д аж ахуй эрхлэх хэлбэр дотор компаниар аж ахуй эрхлэх нь 16 хувийг эзэлдэг боловч ДНБ-ий 90 орчим хувийг үйлдвэрлэдэг. Энэ байдал манай улсад ч адил. Саяхан болтол Эрдэнэт үйлдвэр ХХК манай улсын ДНБ-ий 20 гаруй хувийг дангаараа үйлдвэрлэдэг байсан бол Оюу Толгой ХХК бүрэн хүчин чадлаараа ажиллах тохиолдолд ДНБ-ий 30 гаруй хувийг гаргах бололцоотой болно. Энэ мэтээр аль ч улс орны эдийн засгийг компаниар аж ахуй эрхлэх хэлбэр нь нуруундаа үүрч явдаг. Иймд компанийн засаглалыг бэхжүүлэх нь зөвхөн тухайн компанид хамаарах зүйл төдийгүй нийт улс орны чухал асуудлын нэг юм.

Манай орны хувьд компани хэмээх аж ахуй эрхлэх хэлбэр 1990-ээд оноос анх үүсэн бий болсон бөгөөд мөн үеэс дэлхийн нийтлэг жишгээр компанийн үйл ажиллагаа явуулахыг зорьж, түүнд тохирсон хууль, дүрэм, журам гарган, мөрдүүлэн ажиллаж байна. Монгол Улсад компанийн үйл ажиллагааг зохицуулсан анхны эрхзүйн зохицуулалт 1991 онд “Аж ахуйн нэгжийн тухай хууль” нэртэй гарч, 1995 онд “Нөхөрлөл, компанийн тухай хууль”, 1999 онд “Компанийн тухай хууль” болон өөрчлөгдөж ирсэн ба 2013 онд уг хуулийг шинэчлэн найруулсан. Түүнчлэн энэхүү хуулийн хүрээнд Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагаас шаардлагатай харилцааг илүү нарийвчлан зохицуулсан дүрэм журам, стандартуудыг гарган мөрдүүлж байна. Ингэхдээ эдгээр хууль, дүрэм, журмыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг жишигт нийцүүлэн боловсронгуй болгож ирсэн боловч амьдрал дээр эдгээр хууль, дүрэм, журмын хэрэгжилт төдий л хангалттай биш байгаагаас манай улсын компаниудын засаглал шаардлагатай хэмжээнд сайжирч чадахгүй байна.

Энэхүү үнэлгээний ажил нь манай орны эдийн засагт нөлөө бүхий төрийн өмчит уул уурхайн компаниудыг сонгон авч, тэдгээрийн засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлон, түүнийхээ үндсэн дээр компанийн засаглалыг цаашид сайжруулах зөвлөмжийг компани бүрээр гаргаж тэдгээрт өгөх зорилгоор хийгдсэн бөгөөд түүний үр дүнг Та бүхэнд толилуулж байна.

Тайлан нь оршил хэсэг, компанийн засаглал, түүний гол элементийн талаарх товч мэдээлэл, уул уурхайн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын засаглалын үнэлгээний нэгдсэн дүн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах зөвлөмж зэргээс бүрдэх ба төгсгөлд нь үнэлгээний аргачлал болон тайланд хамаарах зарим мэдээллийг хавсралтаар үзүүлсэн болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ҮНЭЛЭХ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Сүүлийн үед Монгол Улсад компанийн засаглал, түүний дотор төрийн өмчийн оролцоотой компанийн засаглал хангалтгүй байгаа талаар ихээхэн ярьж бичиж байна. Ялангуяа тэдгээрийн дотроос компаниудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, жижиг болон гадаад хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалалт сул байгааг цохон тэмдэглэдэг. Эдгээрийг засаж сайжруулах тухай ерөнхий байдлаар ярьж бичээд үр дүнд хүрэх нь бага, харин энэ талаар бодит ажлын үр дүн гаргах нь чухал байна. Монгол Улсад компанийн засаглалыг сайжруулах ажлыг илүү бодитой, үр дүнтэй болгохын тулд тодорхой компаниас шинэчлэлийг эхэлж, энэ нь бусаддаа үлгэр болон нийтийг хамруулах нь чухал хэмээн үзэж энэхүү судалгааны ажлыг хийсэн болно.

Компанийн засаглалын түвшинг тодорхойлох гэдэг нь эцсийн бүлэгт дэлхий нийтээр даган мөрдөж байгаа нийтлэг сайн жишгийг хэр баримтлан ажиллаж байгааг тухайн улс орон болон компанийн хэмжээнд тодорхойлох үйл ажиллагаа юм. Нийгмийн амьдрал байнга өөрчлөгдөн хөгжиж, тэрхүү өөрчлөлт, шинэчлэлт нь компанийн сайн засаглалын нийтлэг жишигт тусгалаа олж улам баяжин хөгждөг тул тэдгээр мөн чанарыг танин мэдэж, өөрсдийн ажиллагаанд тухай бүр нь тусган авах явдал чухал байна. Монгол Улсад өмнө нь компанийн засаглалын чиглэлээр Дэлхийн Банкнаас *ROCS* буюу “Стандарт, кодексын дагаж мөрдөлтийн тайлан”-гийн хүрээнд Монгол Улсын компанийн засаглалын түвшинг 2007 онд тодорхойлсон бол 2013 онд Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Монгол дахь Зөвлөх үйлчилгээний газраас 2012 оны эдийн засгийн өгөгдөлд тулгуурлан Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 20 том компанийн засаглалын түвшинг тодорхойлсон. Эдгээр үнэлгээ нь улсын хэмжээний ерөнхий түвшинг тодорхойлох тодорхой цөөн тооны нээлттэй компанийг хамарсан үнэлгээ байсан.

Монгол Улс нь байгалийн баялаг ихтэй орон учраас тэрхүү баялгаа ашиглан хөгжих бодлогыг төрөөс баримталж байгаа бөгөөд уул уурхайн чиглэлээр олон компани үйл ажиллагаа явуулж байна. Түүний дотор голлох ашигт малтмал олборлох ажиллагааны ихэнх хувийг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани хэрэгжүүлж, улс орны эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа юм. Эдгээр компанийн засаглал сайн байх нь улс орны хөгжил тогтвортой, зөв явахад чухал нөлөө үзүүлэх болно.

Компанийн засаглалыг үнэлэх энэхүү ажлын хүрээнд Монгол Улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг төрийн өмчит дор дурдсан есөн компанийг сонгон авч засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлж, тэдгээр компанийн засаглалыг сайжруулах талаар төр болон тухайн компанийн зүгээс хийх ажиллагааг Зөвлөмж хэлбэрээр гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх зорилгоор ажиллалаа. Үүнд:

1. Эрдэнэс Монгол ХХК
2. Эрдэнэс Таван толгой ХК
3. Эрдэнэс Оюу толгой ХХК
4. Оюу Толгой ХХК
5. Багануур ХК
6. Шивээ-Овоо ХК
7. Эрдэнэт үйлдвэр ХХК
8. Монголросцветмет ХХК
9. Монатом ХХК эдгээр болно.

ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үнэлгээний аргачлал боловсруулахдаа Олон улсын зарим байгууллагаас гаргасан баримт бичиг, тухайлбал ЭЗХАХБ-аас гаргасан “Компанийн засаглалын зарчим (1999, 2004), ЭЗХАХБ-аас гаргасан “Төрийн өмчийн компанийн засаглалын гарын авлага (2004), ОУСК-аас гаргасан компанийн засаглалын гарын авлага (2004, 2008), АНУ-ын ОУХА-ийн төрийн өмчийн компанийн засаглалын асуулга (2011), Компанийн засаглалын рейтинг тогтоох *Standard & Poor's*-ийн аргачлал (2000), АСЕАН-ы Компанийн засаглалын шалгуур үзүүлэлт (2004) зэрэг материалыг ашиглав.

Үнэлэх үзүүлэлт

Компаниудын засаглалыг үнэлэхэд ихэнх оронд ЭЗХАХБ-аас 1999 онд гаргасан Компанийн засаглалын зургаан зарчмыг¹ үндэс болгон түүний хэрэгжилтийн хүрээнд үнэлгээ өгөх замаар тодорхойлж байна. Бид энэхүү үнэлгээг хийхдээ ЭЗХАХБ-аас гаргасан энэхүү зургаан зарчимтай агуулгын хувьд ижил боловч манай улсын хууль, дүрэм, журамд илүү нийцтэй нэр, томъёолол, ангиллыг хэрэглэсэн гэдэг утгаар нь 2004 онд ОУСК-аас гаргасан гарын авлагад дурдсан компанийн засаглалыг бүрэлдүүлэгч дараах гол элементүүдийг сонгон авсан.

¹ Компанийн засаглалын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын зарчмууд хууд. 16

Үүнд:

1. Хувьцаа эзэмшигч түүний эрхийн хамгаалалт
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)
3. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
4. Гүйцэтгэх удирдлага (ГУ)
5. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал
6. Чухал хэлцлүүд
7. Ногдол ашиг
8. Дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн акт
9. Хяналтын тогтолцоо

зэргийг үнэлгээний үзүүлэлтээр авсан болно.

ОУСК-ийн гарын авлагад үзүүлсэн энэхүү есөн элемент болон ЭЗХАХБ-аас гаргасан зургаан зарчмын хооронд зөвхөн тэдгээрийн доторх ангилал, нэр нь өөр болохоос компанийн засаглалд тавьж буй нийтлэг жишиг агуулга нь ижил байгаа учраас тухайн компанийн засаглалыг тодорхойлоход эцсийн дүнд ялгаа гарахгүй юм.


Үзүүлэлтүүдийг үнэлэх асуулга

Компани бүрийн засаглалын түвшинг тодорхойлох дээр дурдсан үзүүлэлтүүдийг үнэлэхдээ бусад оронд өргөн хэрэглэдэг тухайн ажилтай холбогдох багц асуулгын хэрэгжилтийг үнэлэх аргыг² хэрэглэсэн. Асуулга гэдэг нь сайн засаглалтай байх нөхцөлийг хангахын тулд компани бүрт зайлшгүй хэрэгжүүлэх Монгол Улсын холбогдох хуулийн заалтууд болон сайн засаглалын нийтлэг жишээ, арга ажиллагааг тусгасан асуултууд юм. Үнэлгээний асуулгуудыг компани бүрийн онцлогт тохируулан дээр дурдсан есөн үзүүлэлт бүрээр боловсруулсан бөгөөд асуулгын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-т үзүүлэв.

Асуулгын хэрэгжилтийг үнэлэх

Асуулга бүрийн хэрэгжилтийг Зураг 1-д үзүүлснээр 1-5 оноо өгөх замаар үнэлсэн.

Зураг 1. Үнэлгээний зарчим



Асуулга нь тухайн компанид хэрэгждэггүй тохиолдолд үнэлгээ өгөхгүй бөгөөд түүнийг үнэлгээнд тооцохгүй.

² 2012 ASEAN Corporate governance scorecard

Хуулийн заалт нь нийгмийн нийтлэг жишгийн дагуу тухайн этгээдэд заавал хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэж буй үйл ажиллагааны минимум хэм хэмжээ юм. Иймд тухайн хэрэгжүүлэгч этгээдийн хувьд энэхүү минимумыг өөрийн үйл ажиллагаанд хөгжүүлэн хэрэгжүүлэх бололцоо их байдаг. Засаглал сайтай байх гэдэг нь тухайн үзүүлэлтийн хувьд хуулийн заалтыг өөрийн нөхцөл байдалтайгаа уялдуулан илүү өндөр түвшинд хөгжүүлэх явдал юм. Иймд засаглалын үнэлгээг хуулийн заалтын нөхцөл байдалдаа тохируулан хэрхэн хэрэгжүүлж байгаа байдлаар нь тодорхойлдог.

Компани бүрийн засаглалын үнэлгээг тодорхойлох

Компанийн засаглалын үнэлгээг тодорхойлохдоо үнэлгээний асуулга бүрийн хэрэгжилтэд өгсөн онооны дүнг үндэслэн дээр дурдсан есөн үзүүлэлтийн үнэлгээг гаргаж тэдгээрийн арифметик дунджаар тухайн компанийн засаглалын үнэлгээг гаргасан болно.

Компаниудын засаглалын оноогоор гаргасан дүнг бусад улс орны хувиар тооцсон үнэлгээтэй харьцуулах үүднээс үнэлгээний дээд үзүүлэлт болох 5 оноог 100 хувьтай тэнцүүлэн, 1 оноог 20 хувиар тооцон компаниудын үнэлгээг хувиар гаргасан болно.

Үнэлгээний нэгдсэн аргачлалыг Хавсралт 1, үзүүлэлтүүдийн түвшинг тодорхойлох асуулгыг Хавсралт 2-т үзүүлэв.

2

Компанийн засаглалыг үнэлэх нь

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ЭЛЕМЕНТҮҮД

Компанийн засаглал гэдэг нь Олон улсын санхүүгийн корпорацийн тодорхойлсноор компани үйл ажиллагаа явуулахтай холбогдож компанийн зүгээс оролцогч талуудтайгаа харьцах цогц харилцааны тухай ойлголт юм³. Сайн засаглал нь анх компани байгуулагдсан 1500-аад оны эцсээс хойшх хугацаанд компанийн үйл ажиллагааны талаар хүн төрөлхтөний бий болгосон зүй зохистой ажиллагаа гэж хэлж болно. Тэгэхдээ сайн засаглалын энэхүү зүй зохистой ажиллагаа нь тухайн нийгмийнхээ мөн чанартай уялдан байнга боловсронгуй болж хүн төрөлхтөний сайн сайхан гэж үзэх нийтлэг үнэт зүйлээр баяжин уламжлагдсаар бидний үед иржээ. Эдгээр үнэт зүйл тухайн оронд нийтээр даган мөрдөх хууль, дүрэм, журам, стандартаар дамжин илэрч байдаг. Компанийн засаглал сайн байх нь компанийн үйл ажиллагаа нийгэмд сөрөг үр дагавар үүсгэхгүйгээр урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс болохоос гадна компанийн хувьд гаднаас хөрөнгө татах чухал нөхцөл болдог. Тиймээс үеийн үед аль ч нийгэмд хүний хэрэгцээт зүйлийг үйлдвэрлэн бий болгогч аж ахуйн нэгжүүд түүний дотор компанийн үйл ажиллагаа, засаглалыг сайн байлгахын төлөө хүн төрөлхтөн ажиллаж ирсэн байна.

Компанийн засаглалын талаар олон улсын зарим байгууллагаас гаргаж буй лавлах материалуудаас үзэхэд компанийн засаглалын үндсэн элементүүдэд (i) компанийн хувьцаа эзэмшигч, түүний эрх, (ii) хувьцаа эзэмшигчдийн хурал, (iii) төлөөлөн удирдах зөвлөл, (iv) гүйцэтгэх удирдлага, (v) компанийн үйл ажиллагааны тухай мэдээллийн ил тод, нээлттэй байдал, (vi) компани дээр хийж байгаа чухал хэлцлүүд, (vii) ногдол ашиг, түүний бодлого, (viii) компанийн дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн акт, (ix) компанийн хяналтын тогтолцоо зэргийг хамруулан авч үзэж байна⁴. Иймд компанийн засаглалын түвшинг тодорхойлоход эдгээр элементийн мөн чанарыг авч үзэх явдал чухал юм.

Хувьцаа эзэмшигч, түүний эрх

Хувьцаа эзэмшигч нь компанийг байгуулах үеийн хөрөнгийг бий болгож үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагчийн хувьд компанийн хамгийн чухал этгээд болдог. Энэ утгаараа түүний эрхийг хамгаалах нь ямар ч үед компанийн засаглалын хувьд нэн тэргүүний асуудал болж ирсэн. Улс орнууд хувьцаа эзэмшигчийн эдлэх эрхийг хуулиар тогтоож түүний хэрэгжилтийг компаниуд хангадаг. Хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээсэн энэ үүргээ компани хэрхэн гүйцэтгэж байгаа нь компанийн засаглалын хувьд байнга авч үзэх чухал асуудал болдог.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) нь нэг талаас компанийн томоохон асуудлыг шийдвэрлэдэг утгаараа компанийн эрх барих дээд байгууллага болдог бөгөөд нөгөө талаас хувьцаа эзэмшигч компанийн эзэн гэдэг утгаараа удирдах эрхээ хэрэгжүүлж буй ажиллагаа юм. Иймд компанийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хангах талаар

³ Пособие по корпоративному управлению. Часть I, стр. 29

⁴ Corporate governance manual, Belgrade, 2008, CHAPTER 2. B. The Governance Structure of a company, 39-41

компани хүлээсэн үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа нь засаглалын хүрээнд авч үзэх чухал асуудлын нэг болдог. Ганц хувьцаа эзэмшигчтэй компанид хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн удирдлагын бүтэц байхгүй, харин ийм тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай ойлголт гарч ирдэг. Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тухайн хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хуулиар тусгайлан тогтоосон байдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл ба түүний ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) гэдэг нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд энэ утгаараа компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж түүний хэрэгжилтэд өөрийн тодорхой бүтцээрээ дамжуулан хяналт тавьж удирдан зохион байгуулдаг компанийн удирдлагын байгууллага юм. Компанийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах нь ялангуяа олон хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд бэлтгэл ажил шаардах төвөгтэй асуудал тул тэр бүр хуралдаад байдаггүй. Тиймээс түүний чөлөөт цагт нь компанийн эрх барьдаг ТУЗ-ийн ажиллагаа нь компанийн удирдлагын тасралтгүй ажиллагааг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа ТУЗ нь компанийн засаглалын маш чухал хэсэг болдог.

Гүйцэтгэх удирдлага

Компанийн гүйцэтгэх удирдлага (ГУ) нь ТУЗ-ийн шийдвэрээр томилогдон компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хийсэн ажлынхаа үр дүнг ТУЗ-ийн өмнө хариуцан тайлагнадаг компанийн удирдлагын нэг хэсэг юм. Энэ утгаараа гүйцэтгэх удирдлага нь компанийн засаглалын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог.

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл ил тод, нээлттэй байх нь компанийн хувьцаа эзэмшигч болон түүнд хөрөнгө оруулах хүсэлтэй болон бусад сонирхогч талууд компанийн талаар мэдээлэл авч түүнтэй харьцах бодлогоо тодорхойлоход ашиг тустай байхаас гадна энэхүү мэдээллийг олон нийт авснаараа тухайн компанийн үйл ажиллагаа нийтийн хараа хяналт дор байх нөхцөл бүрдэнэ. Энэ нь компанийн зүгээс аливаа шийдвэр гаргахдаа хянамгай хандах нөхцөл бүрдэж, улмаар компанид ёс бус үйлдэл бага гарах нөхцөл бүрдэнэ. Энэ утгаараа мэдээлэл ил тод, нээлттэй байх нь компанийн засаглалын шууд бүрэлдэхүүн хэсэг биш боловч компанид сайн засаглалыг бүрдүүлэхэд маш чухал нөхцөл болдог тул компанийн засаглалын хүрээнд тусгайлан авч үздэг⁵. Мэдээлэл ил тод бус, хаалттай тохиолдолд сайн засаглалын нөхцөл бүрдэх бололцоогүй юм.

Чухал хэлцлүүд

Шууд утгаараа чухал хэлцэл нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлын адил компанийн засаглалын бүрэлдэхүүн хэсэг биш боловч сайн засаглалыг бүрдүүлэх нэг чухал нөхцөл болдог. Өөрөөр хэлбэл, компани дээр чухал хэлцлүүдийг зохих журмын дагуу хийхгүй бол ихээхэн эрсдэлд орж улмаар дампуурахад хүргэдэг. Иймд компани дээр хийгдэж буй хэлцлүүдээс компанийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг үнийн том дүнтэй болон сонирхлын зөрчил бүхий хэлцлүүдийг чухал хэлцэл гэж үзэж компанийн засаглалын хүрээнд тусгайлан авч үздэг. Ийм хэлцлийг хийх журам, нийтэд мэдээлэх ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг⁶.

⁵ Пособие по корпоративному управлению. Часть IV, стр. 5-62

⁶ Пособие по корпоративному управлению. Часть III, стр. 198-232

Ногдол ашиг, түүний бодлого

Ногдол ашиг авах асуудал нь хувьцаа эзэмшигчдийн суурь эрхүүдийн нэг бөгөөд компанид хөрөнгө оруулсныхаа үр дүнг хүртэж буй хэлбэр тул түүнийг компанийн засаглалын нэг бүрэлдэхүүн болгон авч үздэг. Компани бүр хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэрхэн олгох талаар өөрийн онцлогийг тусгасан бодлоготой байдаг.

Компанийн дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн актууд

Аливаа компани нь хуулийн этгээд байх бөгөөд энэ утгаараа түүний бүхий л үйл ажиллагаа тодорхой хууль, дүрэм журмаар зохицуулагдан, түүний дагуу явагдах ёстой. Компани бүрт түүний засаглалтай холбоотой ажиллагааг зохицуулсан бичмэл дүрэм, журмууд байх ёстой. Хэрэв ийм бичмэл дүрэм журам байхгүй, эсвэл хангалтгүй байх нь тухайн харилцааг эрхтэн дархтанууд өөрсдийн хүсэл зоргоор шийдэхэд хүргэдэг. Энэ нь зарим тохиолдолд компанид сөрөг үр дагавар учруулдаг тул сайн засаглалтай компанид зайлшгүй байх баримт бичгийн жагсаалтыг гаргасан байдаг. Олон улсын зарим байгууллагаас ийм баримт бичгийн талаар тодорхой зааварчлага гаргасан байдаг⁷.

Компанийн хяналтын тогтолцоо

Компанийн үйл ажиллагаанд тавих хяналт нь компанийг удирдах ажиллагааны нэг хэсэг гэж үздэг бөгөөд энэ утгаараа хяналтын тогтолцоо нь компанийн засаглалын нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Компанийн хяналтын тогтолцоо нь компанийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогоос хамаарч янз бүрийн бүтэцтэй байх боловч нийтлэг байдлаараа (i) компанийн хувьцаа эзэмшигчдийн зүгээс тавих хяналт, (ii) компанийн ТУЗ-ийн зүгээс тавих хяналт (зарим тохиолдолд эдгээр нь нэгдмэл байж болдог), (iii) компанийн дотоод хяналт, (iv) мэргэжлийн хяналт буюу хөндлөнгийн аудит зэргээс бүрдэнэ.

Тодорхой компанийн засаглалын түвшинг үнэлэх асуудал нь компанийн засаглалын эдгээр үндсэн элементүүд хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг тодорхойлох явдал. Иймээс бид энэхүү үнэлгээг хийхдээ компанийн засаглалыг бүрдүүлэгч дээр дурдсан гол элементүүдийг үнэлэх үзүүлэлтээр авсан болно.

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ЗАСАГЛАЛЫН ОНЦЛОГ

Та бүхэнд толилуулж буй энэхүү үнэлгээ нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийг хамарч байгаагаараа онцлог юм.

Аль ч улс оронд төр аливаа компанийн хувьцааг нийтэд нь болон тодорхой хэсгийг эзэмшиж болдог бөгөөд үүнийхээ төлөө бусадтай адил эрх, үүрэг хүлээдэг. Төр нь тухайн компанийн хувьд хувьцаа эзэмшигчийн эрх эдэлж, үүрэг хүлээхээс гадна олон төрлийн хууль эрхийн актаар захиргаа, зохицуулалтын маш олон эрх мэдлийг өөртөө авсан байдаг. Энэ нь зарим тохиолдолд төр хувьцаа эзэмшигчийнхээ эрхийг төрийн захиргааны эрхээс үл зааглан, бусдаас илүү эрх эдлэх, компанийн үйл ажиллагааг өөрийн эрх ашигт нийцүүлэх зэрэг компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бий болгодог. Иймд бусад хувьцаа эзэмшигчтэй ижил түвшний хувьцаа эзэмшигч байх үүднээс сайн засаглалын зарчмын хувьд төрийг энэ хоёр үүргээ салгасан байхыг шаарддаг.

⁷ Corporate governance manual , Belgrade, 2008, CHAPTER 3-The Internal Corporate Documents, 52-65

Үүнээс гадна төр нь тодорхой хувь хүний адил бодитой оршин байдаггүй, хуулийн этгээдийн хэлбэрээр байх бөгөөд түүний эрх мэдлийг төрийн нэрээр олон этгээд төлөөлөн хэрэгжүүлдэг. Төрийн эдгээр онцлог байдал нь түүнийг бусад хувьцаа эзэмшигчээс ялгаатай, онцлог хувьцаа эзэмшигч болгодог.

Энэ үүднээс төрийн өмчит болон түүний оролцоотой компанийн засаглал нь бусад компанитай харьцуулахад хувьцаа эзэмшигчийн талаас компанитай харьцах харилцааг ялгамжтай болгодог онцлогтой. Тухайлбал, хувьцаа эзэмшигч хувь хүний хувьд хувьцаа эзэмшигчийн эрхээ өөрөө шууд хэрэгжүүлэх бололцоотой бол төрийн хувьд түүнийг төлөөлсөн этгээд хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдуулан төрийн төлөөллийг хэн, хэрхэн хэрэгжүүлэх вэ гэсэн нэлээд төвөгтэй бөгөөд тодорхой журамлагдсан байх ёстой асуудал гардаг. Практикт төртэй холбоотой энэ харилцааг хууль, дүрэм, журамд нарийн зааж зохицуулаагүйгээс төр эрх, үүргээ хэрэгжүүлэхэд алдаа дутагдал гаргах нь элбэг тохиолддог.

Иймд төрийн өмчит болон түүний оролцоотой компанийн засаглалын түвшинг тодорхойлоход төр өөрийн энэхүү эрх, үүргээ тухайн компанид хэрхэн зөв хэрэгжүүлж байгаа болон энэ ажиллагааг зохицуулж буй хууль эрхийн актуудын зохицуулалт нь дэлхийн нийтлэг жишигтэй хэр нийцэж байгааг тусгайлан авч үзэх шаардлагатай. Энэ нь засаглалын түвшинг асуулгын аргаар тодорхойлж байгаа үед түүнд тохирсон тусгайлсан асуулга гаргах шаардлага гардаг.

Үүнээс гадна тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо, төрөл болон төрийн оролцооны хэмжээ зэргээс хамаарч компанийн засаглалын төрөл, хэлбэр нь өөр өөр болдог. Энэхүү үнэлгээнд хамрагдаж буй компаниуд бүгд төрийн өмчийн болон төрийн өмч оролцоотой боловч засаглалын хувьд нарийвчлан үзэхэд зургаан өөр хэлбэртэй байна. Хүснэгт 1-д компаниудын хэлбэрийг үзүүлэв.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан компаниудийн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн байдал

№	Засаглалын хэлбэр	Компанийн нэр
1	Төр дангаараа хувьцааг нь эзэмшдэг ХХК	Монатам ХХК Эрдэнэс Монгол ХХК
2	ТӨК хувьцааг нь дангаараа эзэмшдэг хаалттай ХХК	Эрдэнэс Оюу толгой ХХК
3	Төрийн өмч давамгайлсан нээлттэй ХК	Багануур ХК Шивээ-Овоо ХК
4	Төрийн өмч давамгайлсан хаалттай ХК	Эрдэнэс ТТ ХК
5	Төрийн өмч давамгайлсан ХХК	Эрдэнэт үйлдвэр ХХК Монголросцветмет ХХК
6	Төрийн өмч оролцсон ХХК	Оюу Толгой ХХК

Иймээс компаниудын хэлбэрт нь тохируулан үнэлгээний үзүүлэлтүүдийн түвшинг тодорхойлох асуулга нь өөр байх ёстой.


3

Уул уурхайн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын үнэлгээний нэгдсэн дүн

ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой есөн компанийн засаглалын түвшинг Хавсралт 1-д заасан аргачлалын дагуу тодорхойлж үзэхэд 0.5-2.4 оноо, хувиар тооцоход 10-48 хувийн үнэлгээ авсан байна.

Зураг 1. Компаниудын засаглалын үнэлгээ (хувиар)



Компаниудын дундаж үнэлгээ нь Хүснэгт 2-т үзүүлснээр оноогоор тооцоход 5 авахаас 1.4, хувиар тооцоход 100 хувь байхаас 28 хувийн үнэлгээ авсан байна. Энэ нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн нийт компани нь засаглалын чиглэлээр гарсан нийтлэг хууль, дүрэм журмыг төдийлөн сайн хэрэгжүүлдэггүй, дутуу дулимаг ханддаг гэсэн ерөнхий дүгнэлт өгч болохуйц байна. Нэгэнт хууль, дүрэм, журмын заалтыг төдийлөн сайн хэрэгжүүлэхгүй байна гэдэг нь тэдний ажиллагаанд ихээхэн эрсдэл үүсэж байгааг харуулна.

Хүснэгт 2. Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын нэгдсэн үнэлгээ

№	Компанийн нэр	ХЭ, түүний эрхийн хамгаалалт	ХЭХ	ТУЗ	ГУ	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Чухал хэлцэл	Ногдол ашиг	Дүрэм болон бусад эрхийн актууд	Хяналтын тогтолцоо	Ерөнхий үнэлгээ	
											оноо	%
1	Оюу Толгой ХХК	2.2	2.9	3.1	3.0	2.1	1.0	0	3.6	3.6	2.4	48
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	2.5	0	1.1	2.0	0	0.5	4.5	3.5	3.7	1.9	38
3	Монголросцветмет ХХК	2.3	0	1.1	2.0	0	0.8	3.0	3.5	3.0	1.7	36
4	Шивээ-Овоо ХК	2.2	2.4	2.4	1.6	0.2	0.5	1.6	2.6	2.9	1.8	36
5	Эрдэнэс ТТ ХК	0.8	1.0	1.7	0.8	0.3	1.0	0	2.1	3.1	1.2	28
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.4	1.8	1.5	1.6	0.3	0.4	0	1.6	0.25	1.1	22
7	Багануур ХК	1.8	1.5	2.1	1.9	0.3	0.5	0	2.2	2.8	1.5	20
8	Эрдэнэс Монгол ХХК	0.9	1.2	1.1	2.0	0.7	0.4	0	2.6	2.4	1.2	16
9	Монатом ХХК	1.4	0.7	1.0	0.3	0.1	0.1	0	1.0	0.2	0.5	10
	Компаниудын дундаж үнэлгээ	1.7	1.2	1.7	1.7	0.4	0.6	1.0	2.6	2.7	1.4	28
	Авах ёстой дээд үнэлгээ	5.0	5.	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	100


Хууль, дүрэм, журам сахин биелүүлэх гэдэг нь сайн засаглалын шаардлагыг хангалаа гэсэн үг биш. Хуулийн заалт нь аливаа хийх ёстой зүйлийн минимум хэмжээг заадаг. Сайн засаглал гэдэг нь хууль, дүрэм журмын заалтыг өөрийн онцлогтоо тохируулан илүү сайн нарийвчлан хөгжүүлэх явдал. Иймд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниуд засаглалаа сайжруулах, энэ чиглэлээр гарсан хууль, дүрэм, журмын хүрээнд өөрийн ажиллагаагаа журамлан ажиллахаар барахгүй тэдгээр дүрэм журмыг онцлогтоо тохируулан хөгжүүлэн баяжуулж ажиллах шаардлагатай байгааг харуулна. Ялангуяа нэгээс доош онооны үнэлгээ авсан компаниуд нь засаглалдаа дорвитой өөрчлөлт хийж, засаглалын чиглэлийн дүрэм заавруудыг үйл ажиллагааны онцлогтоо тохируулан нарийвчлан гаргаж түүнийгээ мөрдөн ажиллах шаардлагатай юм.

Компаниудын хувьд дээд үнэлгээг Оюу Толгой ХХК (2.4 оноо) авсан бол доод үнэлгээг Монатом ХХК (0.5 оноо) авч компаниудын дундаж үнэлгээ нь 1.4 оноо болсон байна. Компаниудын авсан болон үнэлгээний үзүүлэлтүүдийн дээд, доод, дундаж оноог Зураг 2-т үзүүлэв.

Компаниудын дээд доод, дундаж үнэлгээг засаглалын үндсэн элементүүдээр авч үзвэл:

- *Хувьцаа эзэмшигч, түүний эрхийн хамгаалалтаар* дээд үнэлгээг (2.3 оноо) Эрдэнэт үйлдвэр ХХК авсан бол доод үнэлгээг (0.8 оноо) Эрдэнэт ТТ ХК авч тэдгээрийн дундаж үнэлгээ 1.7 оноо байна. Эрдэнэт ТТ ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах талаар тодорхой ажил хийгээгүй учраас үнэлгээ нь доогуур гарчээ.
- *Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж буй байдлаар* Оюу Толгой ХХК дээд үнэлгээ (2.9 оноо) авсан бол Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-иуд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийхгүй байгаагаас "0" оноо авсан ба компаниудын дундаж үнэлгээ нь 1.2 оноо болсон байна.
- *ТУЗ-ийн үйл ажиллагаагаар* Оюу Толгой ХХК дээд үнэлгээ (3.1 оноо) авсан бол Монатом ХХК ТУЗ-ийн гишүүдийг зохих ёсоор нь бүрдүүлж ажиллуулахгүй байгаа учраас доод үнэлгээ (1.0 оноо) авсан байна. Дундаж үнэлгээ нь 1.7 гарсан байна.
- *Гүйцэтгэх удирдлагын хувьд* Оюу Толгой ХХК дээд үнэлгээ (3.0 оноо) авсан бол Монатом ХХК доод үнэлгээ (0.3 оноо) авч дундаж нь 1.7 оноо гарсан байна.

Зураг 2. Компанийн болон үнэлгээний үзүүлэлтүүдийн авсан онооны дундаж ба дээд, доод хэмжээ



- *Мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар* Оюу Толгой ХХК дээд үнэлгээ (2.1 оноо) авсан бол Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-иуд үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байгаа учраас “0” оноогоор доод үнэлгээг авсан байна. Дундаж оноо нь 0.4 байна.
- *Чухал хэлцлийг хийж байгаа байдалд* дээд үнэлгээг Багануур ХК (1.9 оноо), Монатом ХХК доод үнэлгээг (0.1 оноо) авч, дундаж нь 0.8 оноо гарсан байна.
- *Ногдол ашиг хуваарилах үзүүлэлтээр* Эрдэнэт үйлдвэр хамгийн дээд үнэлгээ (4.5 оноо) авсан бол ногдол ашиг хуваарилахгүй байгаа тул Багануур ХК, Монатом ХХК, Оюу Толгой ХХК, Эрдэнэт ТТ ХК, Эрдэнэт Оюу толгой ХХК, Эрдэнэт Монгол ХХК-иуд “0” оноогоор доод үнэлгээ авч, дундаж оноо 1.1 байна.
- *Дүрэм болон бусад эрхийн актуудын хувьд* Оюу Толгой ХХК болон Эрдэнэт үйлдвэр ХХК дээд үнэлгээ (3.6 оноо) авсан бол Монатом ХХК доод үнэлгээ (1 оноо) авч дундаж нь 2.6 байна.
- *Хяналтын тогтолцоо* тодорхой хэмжээнд бий болж ажиллагаа нь тогтворжсон гэдэг утгаараа Эрдэнэт үйлдвэр ХХК дээд үнэлгээ (3.7 оноо) авсан бол ийм тогтолцоо харахан бүрэн хэмжээнд бүрдэж чадаагүй учраас Монатом ХХК доод үнэлгээ (0.2 оноо) авч, компаниудын дундаж оноо 2.7 гарсан байна.

Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын энэхүү үнэлгээг Азийн зарим орон болон Монгол Улсын нээлттэй хувьцаат компанийн засаглалын талаар хийгдсэн үнэлгээний дүнтэй харьцуулах зорилгоор тодорхой тайлбартайгаар Хүснэгт 3-т үзүүлээ.

Хүснэгт 3. Азийн зарим орны компанийн засаглалын үнэлгээний дүн

№	Улс орны нэр	Үнэлгээ хийгдсэн он	Үнэлгээ /хувиар/	Тайлбар
1	Вьетнам	2009	43.9	Улсын нэгдсэн үнэлгээ
2	Хонгконг	2008	72.0	“-
3	Тайланд	2011	77.0	“-
4	Филиппин	2008	72.0	“-
5	Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Top 20 компанийн дундаж	2013	27.5	Нээлттэй ХК-ийн үнэлгээ
6	Монгол Улсын уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компанийн дундаж	2014	28.0	Төрийн өмчит компанийн үнэлгээ

Эндээс харахад Монгол Улсын компаниудын засаглалын түвшин нийтдээ доогуур байна. Дотооддоо авч үзэхэд төрийн өмчит компанийн засаглалын түвшин нь нээлттэй хувьцаат компанитай ойролцоо байгаа нь харагдаж байна. Гэхдээ нээлттэй хувьцаат компанийн хүрээнд хийгдсэн 2013 оны үнэлгээ нь бидний хийж буй энэхүү үнэлгээтэй адил компани дээр нь очиж судалгаа хийж гаргаагүй, зөвхөн нийтэд нээлттэй байгаа болон компанийн засаглалын чиглэлээр ажилладаг байгууллагуудын бэлэн мэдээлэл, баримт бичгийн хүрээнд үндэслэн гаргасан тул засаглалын түвшин нь харьцангуй доогуур гарсан байх магадлалтай.

Төрийн өмчит уул уурхайн компани бүрийн засаглалын үнэлгээг Зөвлөмжийн хамт тусгайлан эмхэтгэл болгож компани тус бүрт хүргүүлсэн тул энэхүү тайланд үнэлгээг нэг бүрчлэн авч үзээгүй болно.

ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БА ТҮҮНИЙ ГОЛ ЭЛЕМЕНТҮҮДЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын нэгдсэн үнэлгээг засаглалын үндсэн есөн үзүүлэлтээр авч үзвэл компаниуд нийтдээ дүрэм ба бусад эрхийн акт, тэдгээрийн агуулга, хяналтын тогтолцоо гэсэн үзүүлэлтээр дээд оноо аваагүй боловч бусад үзүүлэлтээс илүү өндөр буюу 2.6-2.7 оноо авчээ. Энэ нь төрийн өмчит уул уурхайн компаниудын хувьд хяналтын тогтолцоо болон засаглалын зарим дүрэм, журам тодорхой хэмжээгээр сайжрах хандлагатайг харуулж байна. Эдгээр үзүүлэлтийн хүрээнд одоо байгаа дүрэм журмыг илүү тодорхой болгох, сайн засаглалын зарим нэмэлт баримт бичиг боловсруулах шаардлага бий. Энэ талаар компани бүрт өгсөн Зөвлөмжүүдэд тодорхой жишээгээр үзүүлсэн болно.

Бусад үзүүлэлт дотроос мэдээллийн ил тод нээлттэй байдал, зарим чухал хэлцлийг хийж буй байдал гэсэн хоёр үзүүлэлтээр 0.4-0.5 оноо авсан нь хэт доогуур үнэлгээ бөгөөд эдгээр үзүүлэлтийн хүрээнд төрийн өмчит компаниудад хуульд заасны дагуу хийх ёстой ажиллагаа хийгдэхгүй байгааг харуулна. Компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал гэдэг нь хувьцаа эзэмшигч болон бусад сонирхогч талууд компанийн талаар шаардлагатай мэдээллээ цаг тухайд нь авч тухайн компанитай харьцах харилцааны бодлогоо гаргах, нөгөө талаар авсан мэдээллээ ашиглан компанийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих бололцоог хангах чухал үйл ажиллагаа юм. Зарим чухал хэлцлийн хувьд тэдгээрийг компани зөв хийснээр аливаа алдагдал хүлээхгүй байх, компанийн эрх бүхий албан тушаалтнууд компанийн хөрөнгийг өөртөө ашигтайгаар зарцуулах бололцоо гаргуулахгүй байх зэрэг ач холбогдолтой юм. Ийм учраас эдгээр үзүүлэлтийг компанийн засаглалыг тодорхойлоход өндөр ач холбогдолтой буюу нийт үнэлгээний 50 хувийг бүрдүүлэх үзүүлэлт болгон авсан.

Үүнээс гадна үнэлгээнд хамрагдсан компаниудын засаглалын түвшинг бууруулж буй үзүүлэлтүүд бол компанийн эрх барих байгууллагууд болох ТУЗ болон ХЭХ-ын ажиллагаа байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтээр 1.2-1.7 оноо авсан нь хангалтгүй үнэлгээ юм. ХЭХ нь компанийн хувьд эрх барих дээд байгууллага, ТУЗ нь хурлын чөлөөт цагт компанийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргадаг удирдлагын чухал хэсэг. Иймд компанийн эдгээр удирдлагын бүтэц зохион байгуулалт, томилгоо болон үйл ажиллагаа нь хуульд заасны дагуу явагдахгүй бол түүнээс үүсэн гарах үр дагавар нь ихээхэн эрсдэл бий болгодог.

Эдгээр үзүүлэлтийг үнэлэх асуулгуудын хэрэгжилтэд өгсөн үнэлгээнээс харахад төрийн өмчит компанийн ХЭХ болон ТУЗ-ийн ажиллагаанд төрөөс хувьцаа эзэмшигчийн хувьд оролцох оролцоо, төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй байдал нь сайн засаглалын үүднээс нэг мөр болж цэгцрээгүй, зарим тохиолдолд хуульд заасны дагуу биш байх, асуудалд хэлбэр төдий хандах, эсвэл төр хувьцаа эзэмшигчийн эрхээ захиргааны эрхтэйгээ хольж хутган, хууль бусаар компанийн ажиллагаанд шууд оролцох зэрэг сөрөг зүйл их байгаа нь харагдаж байна. Энэ бүхэн нь компанийн засаглалын үнэлгээг бууруулах томоохон хүчин зүйл болсон. Үүний зэрэгцээ төрийн өмчит компанийн хувьд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх ажиллагааны зохицуулалт нь төрийн оролцооны хэмжээтэйгээ уялдан компани бүрт ялгаатай байхаар зохицуулагдаж чадаагүй байна. Жишээлбэл, төр нийт хувьцааг нь эзэмшдэг компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхой бус байна. Мөн төрийн өмчит компанийг анх байгуулахад нь төрийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заахгүй байх, нэр цохсон хэдий ч түүний эрх хэмжээг тодорхойлж өгөөгүй зэргээс төрийн төлөөллийг хэрэгжүүлэхэд тухайн албан тушаалтны үзэмжээр асуудал шийдэгдэхэд хүрч байна. Иймд төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах үүднээс төрийн төлөөллийн мөн чанар, түүнийг хэрэгжүүлэх ажиллагааны журмыг компани дахь төрийн оролцооны онцлогт тохируулан тодорхой болгох шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Үүнтэй холбогдуулан төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах үүднээс төрөөс хийх ажлын талаар Зөвлөмж боловсруулан энэхүү тайлангийн төгсгөлд үзүүлсэн болно. Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээг засаглалын гол элементүүдээр авч үзсэн дүнг дараах байдлаар үзүүлэв.

1. Компанийн засаглал ба хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалт

Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах гэдэг нь аливаа компанийн хувьд хөрөнгө оруулагч хөрөнгө оруулсныхаа төлөө эрхээ эдлэх нөхцөлийг компанийн зүгээс ханган өгч буй чухал ажиллагаа юм. Энэ нөхцөлийг хэр сайн хангана тэр хэмжээгээр компанид хөрөнгө татах нөхцөл бүрдэнэ. Иймд компанийн засаглалын түвшинг тодорхойлох ажиллагааны нэг хэсэг нь тухайн компани хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчийнхээ эрхийг хэрхэн хамгаалж байгааг тодорхойлох явдал юм. Төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээний энэхүү ажилд хувьцаа эзэмшигчийнхээ эрхийг хамгаалж буй байдлыг компани бүрийн онцлогт тохируулан 12-16 асуулгын хэрэгжилтэд үнэлгээ өгөх замаар тодорхойлсон. Хүснэгт 4-т төрийн өмчит компаниудад хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалтад өгсөн үнэлгээг оноогоор болон хувиар харуулав. Энэ үзүүлэлтээр Эрдэнэт үйлдвэр ХХК бусдаасаа илүү оноо авсан нь тус компани хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхийн нэг болох оруулсан хөрөнгөндөө тохирсон ногдол ашиг авах эрхийг төрийн өмчийн компаниуд дотор ганцаараа жил бүр тогтмол хэрэгжүүлдгээс гадна хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг баталгаажуулах, түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг хөрөнгийн бүртгэлд цаг тухайд нь үнэн зөв бүртгэн тайлан балансаа тогтмол тусган үзүүлдэгийн үр дүн юм. Тэгэхдээ тус компани хувьцаа эзэмшигчдийн эрхээ эдлэх хууль ёсны нөхцөл болох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөөгүй, хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь авах бололцоог хангаагүй зэргээсээ болоод дээд үнэлгээ авч чадаагүй байна. Уг үзүүлэлтээр тус компани 2.3 оноо буюу 46 хувийн үнэлгээ авчээ.

Хүснэгт 4. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалалтын үнэлгээ

№	Компанийн нэр	ХЭ-ийн эрхийн хамгаалалт	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	2.2	44
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	2.3	46
3	Монголросцветмет ХХК	2.3	46
4	Шивээ-Овоо ХК	2.2	44
5	Эрдэнэс ТТ ХК	0.8	16
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.8	36
7	Багануур ХК	1.8	36
8	Эрдэнэс Монгол ХХК	0.9	18
9	Монатом ХХК	1.4	28
Компаниудын дундаж үнэлгээ		1.7	34
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Бусад компани 0.8-2.2 оноо авсан бөгөөд эдгээрийн дундаж нь 1.7 байна. Энэ нь төдийлөн сайн үнэлгээ биш бөгөөд ийм доогуур үнэлгээ авсан гол шалтгаан нь төрийн өмчит компаниуд (Шивээ-Овоо ХК-иас бусад) хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэх гол нөхцөл болох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хуульд заасны дагуу албан ёсоор зөв хөтлөөгүй, Эрдэнэт үйлдвэр ХХК-аас бусад компани ногдол ашиг хуваах эсэх талаар хуульд заасан хугацаанд шийдвэр гаргадаггүй, энэ талаараа хувьцаа эзэмшигчдэдээ тодорхой мэдээлэл өгдөггүй, хувьцаа эзэмшигчдэд хуульд заасны дагуу компанийхаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь хүргэдэггүй зэрэгтэй холбоотой. Компани бүрт хүргүүлж буй тайланд тухайн компанийн үнэлгээг тодорхой үзүүлснээс гадна доогуур үнэлгээ авсан асуулгуудын хэрэгжилтийг хэрхэн засаж сайжруулах Зөвлөмжийг тусгайлан оруулсан болно.

2. Компанийн засаглал ба Хувьцаа эзэмшигчдийн хурал

Монгол Улсын Компанийн тухай хуульд Хувьцаа эзэмшигчдийн хурал бол компанийн эрх барих дээд байгууллага гэж заасан. Ийм утгаараа аливаа компанийн ХЭХ-ын дээр удирдлагын өөр бүтэц байхгүй гэсэн үг. Нөгөө талаасаа, уг хурал нь хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийг удирдах болон түүний үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхээ хэрэгжүүлэх хамгийн гол хэрэгсэл, арга ажиллагаа нь болдог. Энэ бүхнээс үзэхэд компанийн засаглалыг бүрдүүлэгч гол элементийн нэг нь гарцаагүй ХЭХ болох нь харагдана.

Хүснэгт 5. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хувьцаа эзэмшигчийн хурлын ажиллагаанд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	ХЭ-ийн хурал	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	2.9	58.0
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	0	0
3	Монголросцветмет ХХК	0	0
4	Шивээ-Овоо ХК	2.4	48.0
5	Эрдэнэс ТТ ХК	1.0	20.0
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.5	30.0
7	Багануур ХК	1.5	30.0
8	Эрдэнэс Монгол ХХК	1.2	24.0
9	Монатом ХХК	0.7	14.0
Компаниудын дундаж үнэлгээ		1.2	24.0
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100.0

Энэхүү үнэлгээнд төрийн өмчийн компаниудын ХЭХ-ын ажиллагаа нь компаниудын онцлогоос хамааран 9-19 асуулгын хүрээнд үнэлгээ хийгдсэн. Үнэлгээний дүнг Хүснэгт 5-д үзүүлсэн бөгөөд үүнээс харахад компаниуд 0-2.9 оноо авч, дундаж нь 1.2 байна. ХЭХ-ын хувьд ийм доогуур үнэлгээ авсан гол шалтгаан нь төр дангаараа бүх хувьцааг эзэмшдэг компанийн хувьд ХЭХ-ын бүрэн эрхийг төр өөрөө хэрэгжүүлэх талаар тодорхой нарийвчилсан дүрэм журам байхгүй, нэг мөр болж журамлагдаагүйгээс хэрэгжилтэд гарч буй алдаатай ажиллагаа, мөн ХЭХ-тай компанид энэхүү хурлын ажиллагаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх ажиллагаа төдийлөн зөв явагдахгүй байгаа зэрэгтэй холбоотой.

ХЭХ-ын хувьд Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК хоёр “0” үнэлгээ авсан нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулж буй гэрээ болон компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчид тодорхой асуудлыг шийдэхээр заасан боловч ТУЗ-ийг компанийн эрх барих дээд байгууллага хэмээн зааж, ХЭХ гэдэг удирдлагын бүтэц байхгүй мэт болгосонтой холбоотой. Гэтэл Монгол Улс болон ОХУ-д компанийн үйл ажиллагааг зохицуулсан эрхзүйн баримт бичгүүдэд аливаа компани ХЭХ гэсэн удирдлагын бүтэцтэй байх бөгөөд тэр нь компанийн хувьд бодлогын чухал асуудлуудыг шийддэг байхаар хуульчилсан. Тиймээс дээрх компаниудад хүргүүлж буй үнэлгээний тайланд холбогдох дүрэм, гэрээндээ ХЭХ-ыг тусгасан өөрчлөлт оруулан журамлах Зөвлөмжийг өгсөн.

3. Компанийн засаглал ба ТУЗ, түүний ажиллагаа

ТУЗ нь компанийн ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага байдаг бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн бүх компани том, жижгээс үл шалтгаалан ТУЗ гэсэн удирдлагын бүтэцтэй байх ба түүний гишүүдийн тоо нь есөөс дээш байна гэж заасан. Үүнээс гадна төрийн өмчийн компанийн ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс дээш хувь нь хараат бус гишүүд байх ба ТУЗ нь өөрийн дэргэд нэр дэвшүүлэх, аудитын, цалин урамшууллын гэсэн гурван хороотой байхаар хуульчилсан. Үүнээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар сайн засаглалтай компаниудаас гаргасан баримт бичгүүдийн олон загвар байдаг. Энэ бүхний хүрээнд ТУЗ-ийн ажиллагаанд дүгнэлт өгөх 45-55 асуулгыг компаниудын онцлогт тохируулан боловсруулж хэрэгжилтэд 0-5 оноо өгөх замаар ТУЗ-ийн ажиллагааг үнэлсэн. Хүснэгт 6-д төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн ажиллагаанд өгсөн үнэлгээг үзүүлэв.

Хүснэгт 6. Төрийн өмчит уул уурхайн компаниудын ТУЗ-ийн ажиллагаанд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	ТУЗ-ийн ажиллагаа	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	3.1	62
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	1.1	22
3	Монголросцветмет ХХК	1.1	22
4	Шивээ-Овоо ХК	2.4	48
5	Эрдэнэс ТТ ХК	1.7	34
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.5	30
7	Багануур ХК	2.1	42
8	Эрдэнэс Монгол ХХК	1.1	22
9	Монатом ХХК	1.0	20
Компаниудын дундаж үнэлгээ		1.7	34
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Энэхүү хүснэгтээс харахад компаниудын ТУЗ-ийн үнэлгээ нь 1-3.1 оноо авч дундаж нь 1.7 гарсан байна. Энэхүү үнэлгээг гаргахдаа ТУЗ-ийн ажиллагааг:

- а. ТУЗ-ийн дарга, гишүүд
- б. ТУЗ-ийн хороод
- в. ТУЗ-ийн хурал

- г. ТУЗ-ийн ерөнхий ажиллагаа
- д. ТУЗ-ийн НБД
- е. Бусад ажиллагаа

гэсэн зургаан чиглэлд хуваан компани бүрийн онцлогт тохирсон 45-55 асуулгаар үнэлсэн.

ТУЗ-ийн үнэлгээгээр Оюу Толгой ХХК бусад компаниудаас илүү өндөр үнэлгээ (3.1 оноо) авсан байна. Тус компани нь гадаадын том хөрөнгө оруулалттай учраас түүний бизнесийн соёл нөлөөлсөн байх магадлалтай. Ер нь гадаадын томоохон хөрөнгө оруулалтын нэг сайн тал нь компанийн сайн засаглалын жишиг ажиллагаа үнэ төлбөргүй орж ирдэгт байгаа юм. Тус компанийн ТУЗ-ийн ажиллагаа тогтмолжиж үйл ажиллагааг нь зохицуулсан нэлээд олон дүрэм, журам гаргаж түүнийхээ дагуу үйл ажиллагаа нь явагддаг нь асуулгуудын хэрэгжилтийн үнэлгээнээс тодорхой харагдаж байна. Гэхдээ сайн засаглалын талаар хийх, өөрчлөх зүйлүүд байсан. Энэ талаар компанийн тайланд тусгасан Зөвлөмжид тодорхой заасан байгаа. Бусад компанийн хувьд ТУЗ-ийн гишүүдийн нэр дэвшүүлэлт, томилгоо, тэдний хийсэн ажилд үнэлэлт өгөх, ТУЗ-ийн ажлын тайлагналт, ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлыг төлөвлөх, ТУЗ-ийн хороод болон нарийн бичгийн даргын ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдтэй компанийн зүгээс ажиллах зэрэг асуудлаар хэвшүүлэх ажил цөөнгүй байгаа нь харагдсан бөгөөд энэ талаар компани бүрийн хийх ажлыг тэдгээрт хүргүүлж буй тайлангийн Зөвлөмжийн хэсэгт тодорхой заасан.

Европын зарим орон болон Монгол Улсын уул уурхайн төрийн өмчит компанийн ТУЗ-тэй холбоотой мэдээлэл

<i>ТУЗ-ийн гишүүдийн тоо</i>		<i>ТУЗ-ийн гишүүдийн дундаж нас</i>		<i>ТУЗ-ийн бүрэлдэхүүнд эмэгтэй гишүүдийн эзлэх хувь</i>	
- Европын дундаж	12.1	- Европын дундаж	58.2	- Европын дундаж	17
- Финлянд	7.5	- Испани	61.2	- Норвеги	39
- Герман	17.0	- Швейцарь	60.6	- Швед	27
- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	9.0	- Итали	60.3	- Финлянд	27
Үүнээс компанид ажилладаггүй нийт гишүүдийн тоонд эзлэх хувь		- Австрали	55.5	- Польш	8.0
- Европын дундаж	80	- Дани	55.4	- Португаль	8.0
- Норвеги, Швед, Швейцарь, Франц	90	- Польш	52.4	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.	
- Португаль, Польш	60	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.		<i>Эмэгтэй даргатай ТУЗ /хувиар/</i>	
- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	100	<i>ТУЗ-ийн даргын нас</i>		- Европын дундаж	4.0
Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн даргыг нэг хүн хашдаг байдал /хувиар/		- Европын дундаж	63.5	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	0
- Европын дундаж	20	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.		<i>Эмэгтэй гүйцэтгэх захиралтай компани /хувиар/</i>	
- Голланд	68	<i>ТУЗ-ийн хараат бус гишүүний дундаж нас</i>		- Европын дундаж	3.0
- Австрали	65	- Европын дундаж	60	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	0
- Франц	65	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.		<i>ТУЗ-ийн бүрэлдэхүүнд гадаад орны иргэний эзлэх хувь</i>	
- Англи	0	<i>Гүйцэтгэх захирлын дундаж нас</i>		- Европын дундаж	30
- Герман	0	- Европын дундаж	52.9	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	0
- Швед	0	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.		<i>ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх /хувиар/</i>	
- Польш	0	<i>Тухайн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажилласан жил</i>		- Жил бүр	70
- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	0	- Европын дундаж	6.1	- 2 жилд 1 удаа	8.0
<i>ТУЗ-ийн дэргэдэх хороодын тоо</i>		- Белги	7.8	- 3 жилд 1 удаа	6.0
- Европын дундаж	3.4	- Испани	7.0	- Дүгнэдэггүй	16
- Англи	4.4	- Финлянд	4.9	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	0
- Герман	4.6	- Норвеги	4.6		
- Норвег	2.3	- Польш	4.6		
- Польш	2.1	- Монголын уул уурхайн төрийн өмчит компани тодорхойгүй.			
- Монголын уул уурхайн төрийн өмчит компани	3				

Аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороог байгуулдаг бол зарим оронд Эрсдэл, стратеги, засаглалын зэрэг хороог нэмж байгуулдаг.

Эх үүсвэр: Herdric and Struggles Corporate Governance Report for 2014. "Towards Dynamic Governace 2014. European Corporate Governance report

4. Компанийн засаглал ба Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг удирдлагын нэг бүрэлдэхүүн нь юм. Иймд гүйцэтгэх удирдлага нь компанийн засаглалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн гүйцэтгэж болохоос гадна тодорхой багаар гүйцэтгүүлж болдог. Мөн гэрээний үндсэн дээр тусгайлан томилсон хуулийн этгээд гүйцэтгэж болно. Аль ч тохиолдолд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана. Үнэлгээнд хамрагдсан төрийн өмчит компаниудын хувьд гүйцэтгэх удирдлагыг нийтэд нь хувь хүн дангаараа гүйцэтгэж байна. Компанийн гүйцэтгэх захирал нь аль ч тохиолдолд ТУЗ-өөс томилогдон түүнд ажлаа тайлагнаж дүгнүүлдэг. Харин түүнийг томилуулах ажиллагаа нь зөвхөн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны ажил, үүрэг байдаг. Төр болон бусад оролцогч талууд төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, эсвэл гүйцэтгэх захирал болох саналаа нэр дэвшүүлэх хороонд ирүүлж, хороо түүнийг нь зохих журмын дагуу хянан үзэж шаардлага хангасан гэж үзвэл нэрийг нь ТУЗ-д оруулж зохих шийдвэрийг гаргуулах ёстой.

Энэхүү үнэлгээнд төрийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлагын ажиллагааг түүний томилгоо болон хийсэн ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг компанийн засаглалтай холбоотой 10 асуулгын хүрээнд авч үзсэн. Үнэлгээний дүнг Хүснэгт 7-д үзүүлсэн бөгөөд түүнээс харахад компаниудын гүйцэтгэх удирдлагын үнэлгээ нь 5 оноо авахаас 0.3-3 оноо авч, дундаж оноо нь 1.7 гарсан байна.

Хүснэгт 7. Төрийн өмчит уул уурхайн компаниудын Гүйцэтгэх удирдлагын ажиллагааны үнэлгээ

№	Компанийн нэр	ГУ-ын ажиллагаа	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	3.0	60
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	2.0	40
3	Монголросцветмет ХХК	2.0	40
4	Шивээ-Овоо ХК	1.6	32
5	Эрдэнэс ТТ ХК	0.8	16
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.9	38
7	Багануур ХК	1.9	38
8	Эрдэнэс Монгол ХХК	2.0	44
9	Монатом ХХК	0.3	6
Компаниудын дундаж үнэлгээ		1.7	34
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Энд Оюутолгой ХХК-ийн үнэлгээ бусдаас өндөр гарсан нь тус компанийн гүйцэтгэх захирлыг томилох ажиллагаа нь хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр тусгайлан зохицуулагдсан бөгөөд түүний дагуу томилгоо нь явагдсантай холбоотой юм. Харин бусад компанийн хувьд үнэлгээ бага байгаа нь гүйцэтгэх захирлын томилгоо нь нэр дэвшүүлэх хорооны оролцоогүй явагдсан, зарим компанид ийм хороо байгуулаагүй, эсвэл байгуулсан ч хороо нь зохих журмын дагуу ажиллаагүй зэрэгтэй холбоотой. Мөн ихэнх компанид төрөөс гүйцэтгэх захиралтай шууд харьцан үүрэг даалгавар өгөх, түүний ажлын чанарыг төр дангаараа дүгнэх зэргээр компанийн ТУЗ-ийн ажиллагааг орхигдуулдаг нь доогуур үнэлгээ авахад хүргэсэн. Эдгээр асуудлыг хэрхэн засах талаар компани бүрийн тайланд тодорхой заав. Мөн томилгооны ажиллагаанд төрөөс оролцох оролцооны талаар энэхүү нэгдсэн тайлангийн төгсгөлд үзүүлсэн төрийн байгууллагуудад өгч буй Зөвлөмжид заасан болно.

5. Компанийн засаглал ба Мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх гол харилцаа нь Компанийн тухай болон Мэдээллийн ил тод нээлттэй байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар зохицуулагддаг. Иймд эдгээр хуулийн холбогдох заалтыг үндэслэн төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг найман асуулгын хүрээнд тодорхойлсон. Үнэлгээний дүнг Хүснэгт 8-д үзүүлэв. Компаниуд дунджаар 0.4 оноо авснаас Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-иуд “0”, бусад компани 0.1- 0.4 оноо авсан нь мэдээллийн нээлттэй ил тод байдал төрийн өмчийн компанид туйлын хангалтгүй байгааг харуулж байна. Дээрх компаниуд бүгд төрийн цөөн тооны эрхтэн дархтаны хүрээнд мэдээллээ хаалттай солилцох замаар, тэдний хүрээнд асуудал шийдэгддэг нь харагдаж байна.

Хүснэгт 8. Төрийн өмчит уул уурхайн компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	2.1	42
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	0	0
3	Монголросцветмет ХХК	0	0
4	Шивээ-Овоо ХК	0.4	8
5	Эрдэнэс ТТ ХК	1.0	20
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	0.5	10
7	Багануур ХК	0,5	10
8	Эрдэнэс Монгол ХХК	0.7	14
9	Монатом ХХК	0.1	10
Компаниудын дундаж үнэлгээ		0.4	8
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Гэтэл төрийн өмчит компани гэдэг нь нийтийн өмчийн компани бөгөөд түүний үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй явагдах ёстой. Оюу Толгой ХХК-ийн хувьд мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүрэн хангалттай биш боловч бусдаасаа арай өндөр (2.1 оноо) үнэлгээ авсан бөгөөд энэ ч утгаараа тус компанийн үйл ажиллагааны сайн, мууг олон нийт байнга хэлэлцдэг. Энэ нь тус компанийн үйл ажиллагаанд нийтийн зүгээс хяналт тавьж буруу зүйлийг засаж сайжруулахад тодорхой тус нэмэр болохоос гадна компани аливаа ажиллагаандаа олон нийт хянаж байгаа гэдэг үүднээс хандаж, аль болох оновчтой шийдвэр гаргахыг эрмэлздэг бөгөөд энэ нь мэдээлэл ил тод, нээлттэй байхын ач холбогдол юм.

Компани бүрт хүргүүлж байгаа үнэлгээний тайланд тухайн компанийн хувьд мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар хийх ажлын Зөвлөмжийг тусгасан болно.

6. Компанийн засаглал ба зарим Чухал хэлцэл хийж буй байдал

Чухал хэлцэл гэдэгт Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй болон өндөр үнийн дүнтэй хэлцлийг хамруулж байгаа бөгөөд эдгээр хэлцэл хэдий хэмжээнд зөв хийгдэнэ төдий чинээ компанид үр дүнгээ өгөх болно. Гэрээ, хэлцэл хийж буй талууд аль болох өндөр өгөөж өөртөө авах сонирхолтой байдаг. Энэ үүднээс гэрээ, хэлцлийн нөгөө тал компанийн эрх бүхий албан тушаалтныг өөртөө татах, түүнтэй хамтрах гэх мэт ажиллагааг явуулах, эсвэл компанийн эрх бүхий албан тушаалтан компанитай ямар нэгэн байдлаар харилцах зайлшгүй шаардлага гардаг. Үүнийг буруутгах үндэс байхгүй. Харин эдгээр ажиллагааг зүй зохистой хийж, компанид хохирол учруулахгүй байх нөхцөлийг ханган ажиллах нь чухал. Ийм нөхцөлийг хангах дэлхийн нийтлэг жишиг ажиллагааг Компанийн тухай хуульд тодорхой заасан байдаг ба хуулийн ийм заалтыг чухал

хэлцлийг үнэлэх асуулга болгон авсан. Үнэлгээний дүнг Хүснэгт 9-д үзүүлсэн бөгөөд компаниуд 0.4-1.9 оноо авч, тэдгээрийн дундаж нь 0.6 буюу хувиар тооцоход дээд үнэлгээ 100 хувь байх ёстой байтал 12 хувийн үнэлгээ авсан байна.

Хүснэгт 9. Төрийн өмчит уул уурхайн компаниудад зарим чухал хэлцэл хийж буй байдалд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	Зарим чухал хэлцэл хийж буй байдал	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	1.0	20
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	0.5	10
3	Монголросцветмет ХХК	0.8	16
4	Шивээ-Овоо ХК	0.5	10
5	Эрдэнэс ТТ ХК	0.8	16
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	1.9	38
7	Багануур ХК	1.9	38
8	Эрдэнэс Монгол ХХК	0.4	8
9	Монатом ХХК	0.1	10
Компаниудын дундаж үнэлгээ		0.8	12
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Дээрх үнэлгээ нь хэт доогуур гарсан бөгөөд үүний шалтгаан нь бодит байдал дээр төрийн өмчийн компаниуд чухал хэлцлийг хуульд зааснаар хийхгүй байх, хийсэн хэлцлээ мөн хуульд заасны дагуу нийтэд мэдээлдэггүй, эдгээр харилцааг хэрэгжүүлэх ажиллагаа нь компани дээр тодорхой журамлагдаагүй зэргээс үүдэлтэй. Цаашид ийм төрлийн гэрээ, хэлцлийг хэрхэн хийх талаар өгөх Зөвлөмжийг компани бүрт өгсөн үнэлгээний тайланд тодорхой заасан.

7. Компанийн засаглал ба Ногдол ашиг

Ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчдийн эдлэх үндсэн эрхийн нэг учраас компанийн засаглалыг үнэлэх үзүүлэлтийн нэгээр авч түүнийг хэрхэн хэрэгжүүлж байгааг компаниудын онцлогт тулгуурлан 3-5 асуулгын хүрээнд үнэлсэн болно.

Хүснэгт 10. Төрийн өмчит уул уурхайн компаниудын ногдол ашиг өгч буй байдалд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	Ногдол ашиг өгч буй байдал	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	0	0
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	4.5	90
3	Монголросцветмет ХХК	4	80
4	Шивээ-Овоо ХК	1.6	32
5	Эрдэнэс ТТ ХК	0	0
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	0	0
7	Багануур ХК	0	0
8	Эрдэнэс Монгол ХХК	0	0
9	Монатом ХХК	0	0
Компаниудын дундаж үнэлгээ		1.1	22
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

Үнэлгээний дүнг үзүүлсэн Хүснэгт 10-аас харахад компаниуд 0-4.5 онооны үнэлгээ авч дундаж үнэлгээ нь оноогоор тооцоход 1.1, хувиар тооцвол 22 хувь гарсан байна. Энд ногдол ашиг байнга хуваарилан хувьцаа эзэмшигчийнхээ эрхийг сайн ханган хэрэгжүүлдэг утгаараа Эрдэнэт үйлдвэр ХХК хамгийн өндөр буюу 4.5 оноо авсан бол Монголросцветмет ХХК ногдол ашиг байнга хуваарилахгүй хэдий ч энэ талаарх дүрэм журмыг харьцангуй сайн хэрэгжүүлж ажилладаг гэдгээрээ 4.0 онооны үнэлгээ авсан байна.

Бусад компанийн хувьд ногдол ашиг хуваарилах хэмжээнд ашигтай ажиллаагүйгээс гадна энэ талаар тодорхой бодлого, дүрэм журамгүйгээс гадна жилийн эцэст ногдол ашгийн асуудлыг тусгайлан авч үзэж хуваарилах эсэх шийдвэр гаргаж байх ёстой хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүйгээс ихэнх компани “0” оноо авчээ. Цаашид ногдол ашгийн талаар компани бүр тодорхой бодлогын баримт бичигтэй болж, түүнийхээ дагуу ажилладаг, жилийн ажил дүгнэх үед ногдол ашгийн асуудлыг заавал хэлэлцэн шийдвэр гаргах талаар компани бүрт өгөх Зөвлөмжийг тэдгээрийн үнэлгээний тайланд тусгасан болно.

8. Компанийн засаглал ба компанийн Дүрэм болон бусад эрхийн акт, тэдгээрийн агуулга

Компанийн үйл ажиллагааг зохицуулдаг хамгийн чухал баримт бичиг нь түүний дүрэм байдаг учраас компанийн засаглалыг үнэлэхэд компанийн дүрэмд тусгах ёстой зүйл бүрэн тусгагдсан эсэх, мөн дүрэм болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг зохих журмын дагуу холбогдох этгээд нь баталсан байдал зэрэг эрх зүйн хувьд зөв байх нь чухал. Үүний зэрэгцээ компанид дүрмээс гадна засаглалын холбоотой бусад ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам, заавар, бодлогын баримт бичиг цөөнгүй байх ёстой. Энэхүү үнэлгээнд төрийн өмчит компанийн засаглалын хүрээнд тухайн компанид зайлшгүй байх дүрэм, журмууд байгаа эсэх, түүнд тусгавал зохих зүйлүүдийг тусгасан эсэх талаар 3-6 асуулгын хүрээнд үнэлгээ өгсөн болно. Хүснэгт 11-ээс харахад компаниуд 1-3.6 оноо авч дундаж нь 2.6, хувиар тооцвол 52 хувьтай гарсан байна.

Хүснэгт 11. Төрийн өмчит уул уурхайн компаниудын дүрэм ба бусад эрхийн актууд, тэдгээрийн агуулгад өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	Компанийн дүрэм ба бусад эрхийн акт, тэдгээрийн агуулга	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	3.6	72
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	3.5	70
3	Монголросцветмет ХХК	3.5	70
4	Шивээ-Овоо ХК	2.6	52
5	Эрдэнэс ТТ ХК	2.1	42
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	2.2	44
7	Багануур ХК	2.2	44
8	Эрдэнэс Монгол ХХК	2.6	52
9	Монатом ХХК	1.0	20
	Компаниудын дундаж үнэлгээ	2.6	52
	Авах ёстой дээд үнэлгээ	5.0	100

Энэ нь бусад үзүүлэлтийн үнэлгээтэй харьцуулахад арай дээгүүр байгаа нь төрийн өмчит компаниудад засаглалын чиглэлийн харилцааг зохицуулах баримт бичиг, дүрэм, журам төдийлөн хангалттай биш боловч тодорхой хэмжээнд байгааг харуулна. Тэгэхдээ гадаадын хөрөнгө оруулалттай гурван компаниас бусад төрийн өмчийн компанийн хувьд шинээр боловсруулах болон одоо байгаа дүрэм, журмын агуулгыг өөрчлөх, илүү ойлгомжтой болгон нарийвчлан сайжруулах шаардлагатай байсан. Энэ чиглэлээр тус компаниудын Зөвлөмжид тодорхой зааснаас гадна зарим зүйлийг нь загвар жишиг хэлбэрээр боловсруулж өгсөн болно.

9. Компанийн засаглал ба компани дахь Хяналтын тогтолцоо

Компанийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо нь хувьцаа буюу эзний хяналт, компанийн буюу дотоод хяналт, хөндлөнгийн буюу мэргэжлийн хяналт зэргээс бүрдэх бөгөөд энэхүү үнэлгээг эдгээр хяналтын тогтолцооны хүрээнд нийт компанид адил найман асуулгын хэрэгжилтээр үнэлсэн болно. Үнэлгээний дүнг үзүүлсэн Хүснэгт 12-оос харахад компаниуд 0.2-3.6 оноо авч дундаж нь 2.7 оноо буюу 54 хувьтай гарсан байна. Компаниудын үнэлгээг авч үзэхэд Монатом ХХК-аас бусад компанид хяналтын тогтолцоо ерөнхийдөө бүрэлдэн тогтсоныг харуулж байна. Гэвч тэдгээрт одоо байгаа тогтолцооныхоо ажиллагааг тогтмолжуулах, ажлынхаа үр дүнг нийтэд мэдээлэх, холбогдох этгээдэд тайлагнан дүгнүүлж байх зэрэг ажиллагааг сайжруулан хэвшүүлэх шаардлага байгаа. Энэ талаар компани бүрт өгсөн Зөвлөмжид тодорхой заасан. Монатом ХХК-ийн хувьд хяналтын тогтолцоогоо хуульд заасны дагуу бий болгон хэвийн ажиллагаанд оруулах талаар нэлээд ажил хийх хэрэгтэй байгааг Зөвлөмжид тодорхой зааж өгсөн.

Хүснэгт 12. Төрийн өмчит уул уурхайн компаниудын хяналтын тогтолцоонд өгсөн үнэлгээ

№	Компанийн нэр	Хяналтын тогтолцоо	
		Оноогоор	Хувиар
1	Оюу Толгой ХХК	3.6	72
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	3.7	74
3	Монголросцветмет ХХК	3.0	60
4	Шивээ-Овоо ХК	2.9	58
5	Эрдэнэс ТТ ХК	3.1	62
6	Эрдэнэс Оюу толгой ХХК	2.8	56
7	Багануур ХК	2.8	52
8	Эрдэнэс Монгол	2.4	48
9	Монатом ХХК	0.2	4
Компаниудын дундаж үнэлгээ		2.7	54
Авах ёстой дээд үнэлгээ		5.0	100

4

Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын түвшин - Дүгнэлт

Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлсны дүнд дараах ерөнхий дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

I. Төрийн өмчит компанийн засаглалын ерөнхий үнэлгээ хэт доогуур түвшинд байна.

Үнэлгээний ерөнхий дүнг авч үзэхэд Оюу толгой ХХК-аас бусад компанийн засаглал хэт доогуур үнэлгээ (дундаж нь 28 хувь) авчээ. Азийн хөгжиж буй зарим улсын компанийн засаглалын ийм төрлийн үзүүлэлт 48-77 хувь байна. Иймд манай улсын компаниуд, түүний дотор төрийн өмчит компаниудын хувьд засаглалаа сайжруулах талаар хийх ажил их байгааг харуулж байна.

II. Төрийн өмчит компанид төрийн төлөөлөл хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тодорхой бус байгаагаас энэ асуудал тодорхой албан тушаалтны үзэл бодлоор шийдэгдэх боломжтой байна. Компаниудын үнэлгээг доош татаж байгаа “0” оноо авсан үзүүлэлтийн жагсаалтаас харахад нийт компанийн хувьд ХЭХ, ТУЗ, гүйцэтгэх удирдлага зэрэгт төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа байдалтай холбоотой асуулгууд түүний ихэнх хувийг эзэлж байна. Үүнтэй холбогдуулан асуулгуудын үнэлгээг авч үзэхэд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх зохицуулалт нь нэг мөр болж цэгцрээгүй, энэ талын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмын заалтууд тодорхой бус, ойлгомжгүй байгаа нь харагдлаа. Ер нь асуудлын шийдвэрлэлт тодорхой бус байх нь албан тушаалтан өөрийн үзэмж, үзэл санаагаар асуудлыг шийдэх бололцоог бий болгодог. Үүнээс үндэслээд өнөөдөр Монголын Улсын төрийн өмчит компанид төрийн төлөөллийн хэрэгжилт тодорхой бус байгаа нь асуудлыг шийдэхэд хүмүүсийн хувийн сонирхол орох нөхцөлийг бүрдүүлж, энэ нь эргээд компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, эдгээртэй холбогдон авилгал өгч авалцах, компанийн хөрөнгө үнэгүйдэх, шаардлага багатай эд барааг өндөр үнээр нийлүүлэх, компаниас хямд үнээр бараа материал гаргах зэрэг сөрөг үр дагавар үүсэх нөхцөл болж байна.

III. Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлттэй болгох талаар гарсан хуулийн заалт хэрэгжихгүй байна.

Компанид сайн засаглал бий болгох нэг чухал нөхцөл нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлттэй болгох явдал. Гэтэл судалгаанд хамрагдсан нийт компани энэ асуудлаар нийтдээ доогуур (0-1оноо) үнэлгээ авсан ба зарим компани, тухайлбал Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-иуд “0” үнэлгээ авсан байна. Энэ нь мэдээллийг ил тод, нээлттэй байлгах асуудлаар төрийн өмчит компаниуд хангалтгүй ажиллаж байгааг харуулна. Мэдээллийг ил тод, нээлттэй болгох талаар сүүлийн жилүүдэд Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд тодорхой заалтууд орсон бөгөөд эдгээр заалтыг мөрдөн ажиллах л үлдээд байна. Энэ талаар өгөх Зөвлөмжийг компани бүрийн тайланд тодорхой заав.

IV. Компани дээр хийгдэж байгаа их болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд хуульд заасны дагуу хийгдэхгүй байгаагаас компанийн үйл ажиллагаанд эрх бүхийн албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувийн сонирхол орох бололцоо их байна.

Компанийн засаглалын үнэлгээг бууруулж буй нэг чухал үзүүлэлт бол тухайн компани дээр хийж байгаа чухал хэлцэл болох их болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хийж байгаа байдал

юм. Энэ үзүүлэлтээр компаниуд 0.4-1 оноо авав. Эдгээр хэлцлийг хийх журам нь Компанийн тухай хуулиар бүрэн зохицуулагдсан байгаа. Гэтэл компаниуд хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас доогуур үнэлгээ авчээ. Чухал хэлцлүүдийг зохих журмын дагуу хийх нь компанид ашигтайгаас гадна компанийн эрх бүхий албан тушаалтан болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн хувийн сонирхлоос компанийг хамгаалах чухал хэрэгсэл болох ёстой.

5

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах-Зөвлөмж

Нээлттэй Нийгэм Форумын санаачлага, санхүүжилтаар Монгол Улсын Уул уурхайн яамтай тохиролцон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн засаглалын өнөөгийн түвшинг тодорхойлж, түүнийг сайжруулах талаар Зөвлөмж боловсруулах ажлыг 2014 оны 4 дүгээр сараас мөн оны 7 дугаар сарыг дуустал хугацаанд хийв.

Судалгаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой есөн компани хамрагдсан бөгөөд тэдгээрийн засаглалын үнэлгээ нь нийт 100 хувийн үнэлгээ авахаас 9.7-24 хувьтай байв. Энэ нь дээрх компаниуд компанийн засаглалын талаар гарсан хуулийн заалтууд болон олон улсын байгууллагаас гаргасан нийтлэг зарчмыг хангалттай сайн хэрэгжүүлж хэвшил болоогүйг харуулж байна. Иймд бид судалгаанд хамрагдсан компани бүрт засаглалаа сайжруулах талаар хийх ажлыг тус бүрийнх нь тайланд дэлгэрэнгүй тусгасан.

Компанийн засаглалын түвшинг бууруулж байгаа нэг гол хүчин зүйл нь Засгийн газар, түүний харъяа байгууллагуудаас тухайн компанитай харьцах ажиллагаа байгаа нь судалгааны явцад харагдсан. Тухайлбал:

- Компанийн эрх барих байгууллага нь ХЭХ, түүний эзгүйд ТУЗ байх ёстой. Энэ талаар Компанийн тухай хуульд тодорхой заасан байгаа. Гэтэл Засгийн газар, түүний байгууллагуудаас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ болон гүйцэтгэх захирлын эрхийн хүрээний асуудлаар шууд, дангаараа шийдвэр гаргах нь ердийн үзэгдэл болсон байна.
- Компанийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс томилогдон, түүнд ажлаа тайлагнаж, үр дүнгээ дүгнүүлж байх ёстой. Гэтэл Засгийн газар, түүний байгууллагуудаас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захиралтай шууд харьцан үүрэг, даалгавар өгөх явдал судалгаанд хамрагдсан ихэнх компанид түгээмэл байна. Энэ нь компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн үүргийг бууруулж ямар ч хариуцлага хүлээдэггүй, ёс төдий удирдлага болгожээ.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ихэнх компанийг анх байгуулахад нь төрийн мэдлийн хувьцааг төрийг төлөөлж эзэмших этгээд болон түүний эрх хэмжээг тодорхой заадаггүйгээс төрийн төлөөллийн хэрэгжүүлэх ажиллагаа ойлгомжгүй, тодорхой бус байна.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэх ажиллагааг компанийн төрөл хэлбэрт нь тохируулан нэг мөр болгон журамлаагүй байгаагаас энэ нь төрийн тодорхой албан тушаалтны үзэл бодлоор явагдахад хүрсэн байна.

Төр нь хувьцаа эзэмшдэг аливаа компанийнхаа хувьд бусад хувьцаа эзэмшигчийн адил эрх, үүрэгтэй. Төр аливаа компанийн нийт хувьцааг нь, эсвэл ихэнх хувьцааг эзэмшдэг гэдэг утгаар компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шууд дангаараа шийдвэр гаргах эрхгүй. Зөвхөн хуульд заасны дагуу тухайн компанийн удирдлагад байгаа өөрийн төлөөллөөр дамжуулан дээр дурдсан эрх барих байгууллагад саналаа оруулах замаар шийдвэрлүүлэх ёстой. Энэ нь дэлхий нийтийн жишиг юм.

Дээр дурдсан асуудлуудтай холбогдуулан компанийн засаглалын түвшинг бууруулж буй төртэй холбоотой асуудлууд болох төрөөс өөрийн хувьцаа эзэмшдэг компанитай өмчлөгчийн хувьд харьцах харилцаа, төрийн төлөөлөл, түүнийг хэрэгжүүлэх журам зэрэг асуудлаар цаашид хийж

хэрэгжүүлэх ажлын талаар дор дурдсан Зөвлөмжийг төрийн зохих байгууллагуудад зориулан гаргаж байна.

1. Шинээр боловсруулж байгаа Төрийн өмчийн тухай хуульд дараах заалтуудыг оруулах

Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар

1. Төр нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид өөрийн өмчлөлтэй холбогдсон эрх үүргээ зөвхөн түүний ХЭХ, ТУЗ дахь өөрийн төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлэх
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гэдэгт энэхүү Зөвлөмжийн 4.1-4.7-д заасан ажиллагааг ойлгохоор хуульд тусгах

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх талаар

1. Төрийн өмчит ХХК, ХК-ийн хувьд түүний хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг УИХ, Засгийн газар болон төрийн хувьцааг эзэмшигч этгээдийн эрх хэмжээнд тохируулан хуваарилж тухайн компанийн дүрэмд зааж өгсөн байх заалт

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зохицуулалтыг хувийн өмчийн нээлттэй компанийхтай адил болгох талаар

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүд, хараат бус гишүүн ба ТУЗ-ийн дэргэд ажиллах хороод зэрэг асуудал нь Компанийн тухай хуулийн нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагааны зохицуулалттай адил байх заалт
2. Төрийн аливаа байгууллага төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаанд оролцохыг хориглох заалт

Төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч этгээд нь төрийн өмчийн оролцоотой ХК болон ХХК-ийн хувьд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийг төлөөлж оролцох этгээдийг томилон тухайн хурлаар хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрт өгөх саналд удирдамж өгөх, шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт өгөх удирдамжийн хүрээнд Засгийн газраас тодорхой чиглэл авч байх заалт
2. Тухайн компанийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодод төрийг төлөөлж орж ажиллах гишүүдийн нэрийг тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгон хүргүүлэх бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү этгээд нь хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хангасан гэж үзвэл төрийг төлөөлж ТУЗ-ийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах, шаардлага хангаагүй тохиолдолд шалтгааныг заан буцааж болох заалт
3. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт төрийг төлөөлж орох гишүүдийн өгөх саналд удирдамж өгөх заалт
4. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гэдэгт дараах ажиллагааг ойлгоно гэсэн заалт
 - 4.1 Төрийн өмчит ХХК болон ХК-д түүний ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх
 - 4.2 Төрийн өмчит ХХК болон ХК-ийн ТУЗ-д төрийг төлөөлөх гишүүнийг томилон, түүгээр дамжуулан тухайн компанийн ТУЗ-ийн эрх хэмжээний асуудлыг хэлэлцэхэд төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар санал оруулах
 - 4.3 Төрийн өмчит ХХК болон ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудалд төрийг төлөөлж буй гишүүний өгөх саналд удирдамж чиглэл өгөх

- 4.4 Төрийн өмчийн оролцоотой ХХК, ХК-ийн ХЭХ-д төрийг төлөөлж оролцох этгээдийг томилж түүгээр дамжуулан хурлаас гарах шийдвэрт төрийн бодлогыг хэрэгжүүлэх
- 4.5 Төрийн өмчийн оролцоотой ХХК, ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд төрийг төлөөлж буй этгээдээс өгөх саналд удирдамж өгөх
- 4.6 Төрийн өмчийн оролцоотой ХХК болон ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээнд тохирох гишүүдийн нэрийг тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд хүргүүлэн томилуулж түүгээр дамжуулан тухайн компанийн ТУЗ-ийн эрх хэмжээний асуудлаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар санал оруулах
- 4.7 Төрийн өмчийн оролцоотой ХХК болон ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудалд төрийг төлөөлж буй этгээдээс өгөх саналд удирдамж өгөх

Төрийн өмчит компанийн төрийн эзэмшилд байгаа хувьцааг төрийг төлөөлж эзэмшигч болох этгээдийн талаар

1. Төрийн өмчит компанийн төрийн эзэмшилд байгаа хувьцааг төрийг төлөөлж эзэмшигч болох этгээдийг Засгийн газар томилох заалт
2. Төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч этгээд нь Засгийн газрын аль нэг, эсвэл хэд хэдэн байгууллага байж болохоос гадна шаардлагатай гэж үзвэл энэхүү төлөөлөлд хувийн болон төрийн бус байгууллага байж болно. Засгийн газар эдгээрийн аль нь байхыг тухайн компанийн үйл ажиллагааны онцлог, Монгол Улсын тухайн үеийн төрийн өмчийн бодлого зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх ба уг шийдвэрт төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчдийн эзэмших хувьцааны тоо хэмжээ, тухайн этгээдийн төрийн хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх эрх хэмжээ, энэ чиглэлээр явуулах үйл ажиллагааны чиглэл зэргийг заасан байна гэсэн заалт

Төрийг төлөөлж компанийн ТУЗ-д сонгогдох этгээдэд тавих шаардлагын талаар

1. Тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай байх
2. Тухайн компанийн онцлогтой холбогдуулан компанийн нэр дэвшүүлэх хорооноос тавьсан шаардлагыг хангасан байх
3. Хувь хүний тухайд багаар ажиллах чадварыг эзэмшсэн байхаас гадна ТУЗ-ийн ажилд оролцох зав чөлөөтэй байх
4. Тухайн компанид болон түүний өрсөлдөгч этгээдийн удирдлагад ажилладаггүй байх
5. Төрийн захиргаанаас бусад төрийн алба хашдаггүй байх
6. Төрийн өндөр албан тушаал хашигчтай аливаа төрлийн холбоогүй байх, ийм холбоотой тохиолдолд түүнийгээ мэдээлсэн байх
7. Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх
8. Төрийн захиргааны албан хаагч болон энэ хуулийн 21.2-д заасан байгууллагын ажилтан байж болох
9. Төрийг төлөөлж тухайн компанийн ХЭХ болон ТУЗ-ийн хуралд оролцох этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс өгсөн удирдамж, зааврын дагуу ажиллаж удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүний төрийг төлөөлөх эрх нь дуусгавар болох үндэслэл болох

10. Төр төлөөлж хуралд оролцож байгаа төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн төрөөс бусад хувийн өмчлөгчөөс төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох гишүүний талаар санал өгөхгүй байх
11. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн төлөөлөгч нь эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглох

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын талаар

1. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани нь дараах мэдээллийг өөрийн цахим хуудасд тавьж нийтэд мэдээлэхийн хамт хувьцааг эзэмшиж буй этгээдийн хүсэлтийн дагуу бичгээр бэлтгэн хүргүүлэх үүрэгтэй байх заалт
 - 1.1 Компанийн дүрэм болон үйл ажиллагааг зохицуулах бусад баримт бичгүүд
 - 1.2 Аудитын дүгнэлт бүхий санхүүгийн жил, улирлын тайлан
 - 1.3 Тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд
 - 1.4 ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын талаарх танилцуулга, тэдэнд олгосон шагнал урамшуулал
 - 1.5 Компанийн томоохон хувьцаа эзэмшигч, тэдний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо
 - 1.6 Компани дээр болсон томоохон үйл явдал
2. Төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч этгээд нь төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийг жилд хоёр удаа гаргаж нийтэд мэдээлдэг байх ба энэ мэдээлэлд санхүүгийн талын мэдээллээс гадна санхүүгийн бус нийтэд зайлшгүй хүргэх нийтлэг мэдээллийг агуулсан байна гэсэн заалтуудыг тус тус оруулах.
2. **Компаниудын дүрэмд “Төрийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” гэсэн тусгай бүлэг оруулж тухайн компанийн хувьд энэ ажиллагаа хэрхэн явагдахыг хуулийн холбогдох заалтын хүрээнд тодорхой болгож журамлах.**
3. **Төрийн төлөөлөл хэрхэн хэрэгжиж байгаа талаар уг ажиллагааг хэрэгжүүлэгч этгээд тусгайлсан тайлан гаргаж түүнийг томилсон этгээдэд өгдөг журамтай болох.**

1. ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК
 2. МОНАТОМ ХХК
 3. ЭРДЭНЭС ОЮУТОЛГОЙ ХХК
 4. МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК
 5. ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК
 6. ОЮУТОЛГОЙ ХХК
 7. ЭРДЭНЭС ТТ ХК
 8. ШИВЭЭ-ОВОО ХК
 9. БАГАНУУР ХК
-

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгуулагдсан он	1978
Хүчин чадал	Жилдээ 26.0 мян тн хүдэр боловсруулах
Өмчийн харьцаа	51:49 (Мон:ОХУ)
Нийт хувьцааны тоо	100

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

№	ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ	
		ОНОО	ХУВЬ
	Компанийн үнэлгээ	1.9	38
1	Хувьцаа эзэмшигч, түүний эрхийн хамгаалалт	2.3	46
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал	0	0
3	Төлөөлөн удирдах зөвлөл	1.1	22
4	Гүйцэтгэх удирдлага	2.0	40
5	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0	0
6	Чухал хэлцлүүд	0.5	10
7	Ногдол ашиг	4.5	90
8	Засаглалтай холбогдох дүрэм, эрх зүйн актууд	3.5	70
9	Хяналтын тогтолцоо	3.7	74



ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ /АСУУЛГА ТУС БҮРЭЭР/

АСУУЛТ	ОНОО
1. Хувьцаа эзэмшигч, түүний эрхийн хамгаалалт	2.5
1.1 ХЭ-ийн бүртгэл хөтлөлт	0
1.2 ХЭ-ийн бүртгэлийн агуулга	0
1.3 ХЭ-ийн ээлжит хурлын үед ХЭ-ийн авах ёстой мэдээллийг бүрэн хүргэдэг эсэх	0
1.4 Хуваарилсан ногдол ашгийг өглөгөөр бичдэг эсэх	5.0
1.5 ХЭХ-аар хэлэлцэх асуудлаар ХЭ саналаа өгөхөд шаардлагатай мэдээллээр бүрэн хангадаг эсэх	5.0
1.6 Ногдол ашиг хуваарилсан байдал	5.0
1.7 ХЭ-д компанийн санхүүгийн талаарх мэдээлэл авах бололцоог хангасан байдал	0
1.8 ХЭ компанийн үйл ажиллагаа болон компани дээр болж буй томоохон үйл явдлын талаар байнгын мэдээлэл авах бололцоог хангасан байдал	0
1.9 Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг төрийг төлөөлөн эзэмшиж буй этгээдийн төлөөлөх хэмжээг тусгайлан тогтоож өгсөн эсэх	0
1.10 ХЭ-ийн эдлэх эрхийг тусгайлан гаргаж нийтэд мэдээлэх	3.0
1.11 ХЭ-д ижил ханддаг эсэх	2.0
1.12 Зарласан болон гаргасан хувьцааг бүртгэлд тусгасан байдал	5.0
1.13 ХЭ-ийн оруулсан хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал	5.0
1.14 Бусдад оруулсан хөрөнгийн бүртгэл	5.0

АСУУЛТ	ОНОО
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал	0
2.1 ХЭХ хуралдуулах тусгайлсан журамтай эсэх	0
2.2 Журамд зохих зүйлийг заасан эсэх	0
2.3 ХЭ-ийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуудаг эсэх	0
2.4 ТУЗ-өөс ХЭХ-ыг хуралдуулах шийдвэр гаргадаг эсэх	0
2.5 ТУЗ-өөс ХЭЭХ хуралдуулах шийдвэрийг хуульд заасны дагуу хугацаанд нь гаргадаг эсэх	0
2.6 Саналын хуудсын загвар ХЭ саналаа өгөх боломжийг хангасан эсэх	0
2.7 Хурлын зарыг хуульд заасны дагуу хүргэдэг эсэх	0
2.8 Тооллогын комиссын үйл ажиллагааг зохицуулсан журамтай эсэх	0
2.9 Хуралд оролцогсдыг хуралд оролцох эрхтэй эсэхийг тодорхойлдог эсэх	0
2.10 Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргадаг эсэх	0
2.11 ТК нь хэлэлцэх асуудалд ирүүлсэн саналын талаар тогтоол гаргадаг эсэх	0
2.12 Хурал даргалагч ба ТК-оос ХЭХ-ын талаар нэгдсэн тайлан гардаг эсэх, түүнийгээ мэдээлдэг байдал	0
2.13 Хурлын зар хүргэх тусгай журамтай эсэх	0
2.14 ХЭХ-аас гарах шийдвэр гаргалт	0
2.15 Хурлаас гаргасан шийдвэрийг нийтэд мэдээлдэг эсэх	0
2.16 ХЭХ хуралдуулах талаар ХЭ-ээс ирүүлсэн хүсэлт шаардлагыг хэрэгжүүлдэг эсэх	0
2.17 ХЭХ-д Төрийн мэдлийн хувьцааг төлөөлөн оролцох этгээдийг томилох этгээд нь тодорхой эсэх	0
2.18 ХЭХ-д оролцох төлөөллийг томилсон шийдвэр гаргадаг эсэх гардаг бол ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийг өгдөг эсэх	0
2.19 ХЭХ-ын материалын хадгалалт	0

АСУУЛТ	ОНОО
3. Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ	1.1
3.1 Нэр дэвшүүлэх хороотой эсэх	0
3.2 Хорооны ажиллах журам байгаа эсэх	0
3.3 Хорооны бүрэлдэхүүний ажиллагаа зохих журмын дагуу явагддаг эсэх	0
3.4 ТУЗ-ийн гишүүдийн нэр дэвшүүлэлт зохих журмын дагуу явагдсан эсэх	0
3.5 ТУЗ-ийн гишүүдийн томилгоо	3.0
3.6 Хараат бус гишүүнийг хаанаас санал болгосон	0
3.7 Хараат бус гишүүнд зохих шаардлага хангасан хүнийг томилсон байдал	0
3.8 ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зохих тооны хараат бус гишүүн байгаа эсэх	0
3.9 Хараат бус гишүүн хуульд заасан шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэх	0
3.10 Хараат бус гишүүнд өгөх урамшуулал бусад гишүүдээс ялгаатай эсэх	0
3.11 ТУЗ-ийн төрийг төлөөлж буй гишүүд хуралд хэлэлцэх асуудлаар санал өгөхдөө удирдамж авдаг эсэх	3.0
3.12 Компанийн зүгээс ТУЗ-ийн гишүүдтэй ажиллах тэднийг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр тусгайлан хангах ажиллагаа	0
3.13 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа	0
3.14 ТУЗ-ийн гишүүдийн ажлын хуваарилалт	0
3.15 ТУЗ-ийн гишүүдийн ажлын дүгнэлт	0
3.16 ТУЗ-ийн гишүүдийн шагнал урамшуулал тэдний ажлын гүйцэтгэлтэй уялдсан эсэх	0
3.17 Гишүүдийн цалин, шагнал нийтэд нээлттэй байгаа эсэх	0
3.18 Гишүүд ажлын лавлагаа материал бүхий тусгайлсан хавтастай эсэх	0
3.19 ТУЗ-ийн дарга ГЗ нэг хүн хашдаг эсэх	5.0
3.20 ГЗ нь ТУЗ-ийн гишүүн эсэх	5.0
3.21 Охин компанийн удирдлагад толгой компанийн удирдлага ажилладаг эсэх	4.0
3.22 ТУЗ-ийн гишүүд ажиллах зав чөлөөтэй эсэх	2.0
3.23 Заавал байх хороодыг байгуулсан эсэх	0
3.24 Хороодын гишүүдийн бүрэлдэхүүн зохих журмын дагуу байгаа эсэх	0
3.25 Хороодын ажиллах журамтай эсэх	0
3.26 Хороодын үйл ажиллагааг зохих түвшинд явуулж буй эсэх	0
3.27 Хороодын ажил дүгнэдэг эсэх	0
3.28 Тодорхой асуудлаар түр болон байнгын ажиллагаатай хороо ажилладаг эсэх	0
3.29 Хороодын гишүүнд ажилласны төлөө урамшуулал олгодог эсэх	0
3.30 ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө	0
3.31 Хурлын тэмдэглэл хөтлөлт, шийдвэр гаргалт	4.0
3.32 Нийтэд мэдээлэлт	0
3.33 Хурлын зар хүргэлт	4.0
3.34 Гишүүд хуралд биеэр болон сонсож оролцох байдал	3.0
3.35 Хурлын хэлэлцэх асуудлыг бэлтгэх	5.0
3.36 Хурлын тэмдэглэл ба шийдвэрийн баталгаажуулалт	4.0
3.37 ХЭХ хуралдуулах шийдвэр гаргах, хэлэлцэх асуудал батлах нь тодорхой эсэх	0
3.38 ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх	0
3.39 ТУЗ-ийн ажлын тайлагналт	0

3.40 ТУЗ-ийн үйл ажиллагаанд дүгнэлт өгдөг эсэх	0
3.41 ТУЗ-ийн гишүүдийн хариуцлагын даатгал хийлгэдэг байдал	0
3.42 Сургалтад хамрагдсан эсэх	0
3.43 КЗ-ын баримт бичгийн эмх цэгц, хадгалалт, хөтлөлт	4.0
3.44 ХЭХ-аас гарч буй шийдвэрийн агуулга, бичлэгийн байдал	0
3.45 ТУЗ-өөс гарч буй шийдвэрүүдийн агуулга, бичлэгийн байдал	4.0
3.46 Оролцогч талуудтай компанийг холбож ажилладаг байдал	2.0
3.47 Хороодтой ажиллах ажиллагаа	0
3.48 Хяналтын бүтэцтэй ажиллах ажиллагаа	3.0
3.49 ХЭ-тэй ажиллах ажиллагаа	4.0
3.50 Мэдээллийг ил тод, нээлттэй болгох ажиллагаа	0
3.51 Бусад талуутай ажиллах ажиллагаа	1.0

АСУУЛТ	ОНОО
4. Гүйцэтгэх удирдлага	2.0
4.1 Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох болон үйл ажиллагааг зохицуулсан тусгай журамтай эсэх	0
4.2 Нэр дэвшүүлэх ажиллагаа	0
4.3 ГЗ-д компанийн онцлогтой уялдсан шаардлага тавьдаг эсэх	4.0
4.4 Гэрээ байгуулалт	4.0
4.5 Томилгоо	3.0
4.6 Үйл ажиллагаа болон гэрээний биелэлтийг тусд нь дүгнэдэг эсэх	5.0
4.7 Ажлын тайлагналт улирал, жилээр	4.0
4.8 Төрөөс ГЗ-тай шууд харьцдаг эсэх	0
4.9 ГЗ-ын ажлыг ТУЗ-өөс өөр төрийн аль нэг байгууллага дүгнэдэг эсэх	0
4.10 ГЗ-ын цалин, урамшууллыг нийтэд мэдээлдэг эсэх	0

АСУУЛТ	ОНОО
5. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0
5.1 Мэдээллийн бодлогын баримт бичигтэй эсэх	0
5.2 ХЭ-ийн бүртгэл түүний дотор том ХЭ-ийн нэр, эзэмшиж буй хувьцааны хэмжээг нийтэд мэдээлэх боломж	0
5.3 Вэб хуудсанд КЗ-ын талаар тусгай булан байгаа эсэх	0
5.4 КЗ-ын вэбийн хөтлөлт	0
5.5 Компани дээр болсон томоохон үйл явдлыг нийтэд тогтмол мэдээлдэг байдал	0
5.6 Санхүүгийн мэдээллийг нийтэд мэдээлдэг эсэх	0
5.7 Санхүүгийн мэдээллийг вэб дээр тогтмол мэдээлдэг эсэх	0
5.8 Худалдан авалтын ажиллагааны гүйцэтгэлийг нийтэд нээлттэй мэдээлдэг эсэх	0
5.9 ТУЗ ба ГЗ-ын цалин, урамшууллыг жилийн тайланд тусгадаг эсэх	0
5.10 Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн жилийн нэгдсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт нийтэд зориулан тусгайлан эмхэтгэл болгон гаргадаг эсэх	0

АСУУЛТ	ОНОО
6. Чухал хэлцэл	0.5
6.1 Их хэлцлийг зохих журмын дагуу шийдсэн байдал	2.0
6.2 Нийтэд мэдээлдэг байдал	0
6.3 Жилийн тайланд тусгадаг байдал	0
6.4 СЗ-тэй хэлцлийг зохицуулсан журамтай эсэх	2.0
6.5 СЗ-тэй хэлцлийг зохих журмын дагуу шийдсэн байдал	0
6.6 Нийтэд мэдээлдэг байдал	0
6.7 Жилийн тайланд тусгадаг байдал	0
6.8 Эрх бүхий албан тушаалтан ЭБАТ хэн байхыг дүрэмдээ тусгасан байдал	0
6.9 ЭБАТ нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг өгсөн байдал	0
6.10 ЭБАТ болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэл нээлттэй байгаа эсэх	0
АСУУЛТ	ОНОО
7. Дүрэм	3.5
7.1 Дүрмийг баталсан байдал	4.0
7.2 Дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг баталсан байдал	4.0
7.3 Дүрэмд зайлшгүй байх ёстой зүйлүүдийг тусгасан байдал	3.0
7.4 Дүрэм нийтэд нээлттэй байгаа эсэх	0
7.5 Засаглалтай холбоотой ажиллагааг зохицуулсан эрхийн актууд байгаа эсэх	3.0
7.6 Нябо бүртгэлийн ББ-тэй эсэх	4.0
7.7 Анхан шатны бүртгэл тодорхой байгаа эсэх	4.0

АСУУЛТ	ОНОО
8. Ногдол ашиг	4.0
8.1 Ногдол ашгийн бодлогын баримт бичиг байгаа эсэх	5.0
8.2 Ногдол ашиг хуваарилсан байдал	5.0
8.3 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргаж буй байдал	3.0
8.4 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт тусгах ёстой зүйлийг тусгасан байдал	2.0
8.5 Хуваарилсан ногдол ашгийг нябо бүртгэлд тусгаж буй байдал	5.0
АСУУЛТ	ОНОО
9. Хяналтын тогтолцоо	3.7
9.1 Компанийн хяналтын тогтолцоог зохицуулсан баримт бичиг байгаа эсэх	5.0
9.2 Аудитын хороо байгуулсан эсэх	5.0
9.3 Хорооны бүрэлдэхүүн	4.0
9.4 Хорооны үйл ажиллагаа	4.0
9.5 Хорооны үйл ажиллагааны тайлагналт, дүгнэдэг байдал	4.0
9.6 Хөндлөнгийн аудитыг сонгох, томилох ажиллагаа	4.0
9.7 Хөндлөнгийн аудитын тайланг нийтэд мэдээлдэг байдал	0
9.8 Дотоод хяналтын тогтолцоо, түүний томилгоо, ажлыг нь дүгнэх ажиллагаа	4.0

МОНАТОМ ХХК

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгуулагдсан он	2009
Өмчийн хэлбэр	Төрийн өмч
Компанийн төрөл	Төрийн өмчит ХХК

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

№	ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ		
		ОНОО	ХУВЬ	
1	Хувьцаа эзэмшигч, түүний эрхийн хамгаалалт	1.4	28	<div style="width: 28%;"></div>
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал	0.7	14	<div style="width: 14%;"></div>
3	Төлөөлөн удирдах зөвлөл	1.0	20	<div style="width: 20%;"></div>
4	Гүйцэтгэх удирдлага	0.3	6	<div style="width: 6%;"></div>
5	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0.1	2	<div style="width: 2%;"></div>
6	Чухал хэлцлүүд	0.1	2	<div style="width: 2%;"></div>
7	Ногдол ашиг	0	0	
8	Засаглалтай холбогдох дүрэм, эрхзүйн актууд	1.0	4	<div style="width: 4%;"></div>
9	Хяналтын тогтолцоо	0.2	10	<div style="width: 10%;"></div>
	Компанийн дундаж	0.5	10	<div style="width: 10%;"></div>



ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ /АСУУЛГА ТУС БҮРЭЭР/

АСУУЛТ	ОНОО
1. Хувьцаа эзэмшигч, түүний эрхийн хамгаалалт	1.4
1.1 ХЭ-ийн бүртгэл хөтлөлт	0
1.2 ХЭ-ийн бүртгэлийн агуулга	0
1.3 ХЭ-ийн ээлжит хурлын үед ХЭ-ийн авах ёстой мэдээллийг бүрэн хүргэдэг эсэх	0
1.4 ХЭ-ийн ээлжит хурлын зарыг ХЭ цаг тухайд нь авах бололцоог хангасан байдал	-
1.5 ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх этгээдэд энэ үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр бүрэн хангагдаг эсэх	3.0
1.6 Ногдол ашиг хуваарилсан байдал	0
1.7 ХЭ-ээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх боломж	4.0
1.8 ХЭ-д компанийн санхүүгийн талаарх мэдээлэл авах бололцоог хангасан байдал	0
